

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-43

1. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	4-33
2. Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсох	33-43

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
05 дугаар сарын 21-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 40 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн;
Чөлөөтэй: Н.Алтаншагай, О.Батнайрамдал, Д.Рэгдэл.

**Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын
хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлогын газрын дарга П.Оюунаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, мөн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Л.Балчинлуvsан, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Отгонцэцэг, Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Оюунбилэг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Болормаа, Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Сэргэлэн, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн, Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Л.Ариунтунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Б.Хэрлэн, О.Саранчулуун, Г.Хосбаяр, Д.Бум-Очир, С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Оюунбилэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Ж.Галбадрах, О.Саранчулуун, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн тавьсан асуултад Ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Ж.Галбадрах, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 21 минут үргэлжилж, ирвэл зохих 15 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 73.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 40 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Ундрам: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн учраас хуралдаан эхэлснийг мэдэгдье. Ирцийг танилцуулъя. Энэ ирсэн нь энэ биз дээ? Дуламын Бум-Очир ирсэн байна, Жанчивын Галбадрах ирсэн байна, Амгаланбаатарын Ганбаатар ирсэн байна, Цэндсүрэнгийн Мөнхтуяа ирсэн байна, Отгоны Саранчулуун ирсэн, Мягмардашийн Сарнай ирсэн, Чинбатын Ундрам ирсэн, Ганбатын Хосбаяр ирсэн, Бадарчийн Хэрлэн ирсэн, Сүхбаатарын Эрдэнэбат ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн чөлөөтэй ийм ирцтэй байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. 2.Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсоно гэсэн ийм 2 асуудал байна. Энэ хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Дамдинням гишүүн ирсэн байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү ирсэн байна. Сангийн яамны ТНБД Ганбат байна уу, Ганбат дарга байна уу? Одоогоор алга байна шүү. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Эрдэнэбат одоогоор харагдахгүй байх юм. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Номин ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД Оюунбилэг ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Болормаа байхгүй байна шүү дээ, байхгүй байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Сэргэлэн ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваацэрэн ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Залуучуудын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батдорж түрүүн байсан, ирсэн байгаа. Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Стратеги бодлого,

төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ариунтунгалаг гэсэн ийм нэр өгсөн байна шүү.

Боловсролын яамны ТНБД Батжаргал ирсэн байна, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлогын газрын дарга Оюунаа ирсэн байна. Энэ Ганбат дарга ирсэн юм уу? Эрдэнэбат дарга ирсэн юм уу? Эдийн засаг, хөгжлийн яамны Эрдэнэбат дарга ирсэн үү? Энэ дээрээ чи чеклэчихсэн байна шүү дээ, ямар хэцүү юм бэ. Шинжлэх ухаан хаана байна вэ, байхгүй байна шүү дээ. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох ирсэн байгаа. Дахиад энийгээ чеклэх. Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан Баттогтох даргыг хэлсэн. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Анар ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Балчинлуvsан ирсэн байна. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж ирсэн байна. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн ирсэн байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Мөнгөнсүх ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга Мөнхтөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Отгонцэцэг ийм хүмүүс өнөөдөр ирсэн байна. Лхагвасүрэн энэ хэн нь юмаа асуудлаа танилцуулах уу, шууд л.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулттай гишүүд байвал нэрсээ өгье. Асуулттай гишүүн байна уу? Би нэг асуулт асуучихъя. Ундармаар асуултыг тасалъя гэдэг шиг. Тийм, асуудалтай холбоотой асуулт байна уу? Танилцуулга хийгдэхгүй юм байна, шууд асуулт юм байна. Нэрээ өгөөрэй, энэ нэр нь гарахгүй байна шүү. Асуулт асуух юм уу? Саранчулуун гишүүнээр тасалъя. Эрдэнэбат гишүүн асуулт асууя. Тийм шууд төлөвлөгөөгөө ярина. Эрэмбэлчихсэн юм байна. Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Надад ердөө 1 л асуулт байна л даа. Тэгэхээр энэ нөгөө соёл урлагийн салбартай холбоотой. Энэ 26 оны төлөвлөгөөнд нэг хөтөлбөр тусгагдаж орж ирсэн нь соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ гэсэн ганцхан ийм хөтөлбөр зорилт орж ирсэн байгаа нь энэ салбарын хувьд үндсэн чиг үүргээрээ хэрэгжүүлэхэд энэ хангалттай байгаа юу? Миний бодлоор энэ 26 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаа гэдэг, энэ хөтөлбөр гэдэг бол энэ салбарын хувьд санхүүжилтийнх нь гол шийдвэр энэ дээр тулгуурлаж гарч байгаа байх. Тэгэхээр энэтэй холбогдуулж би соёл урлагийн салбарын тухай дээр ердөө энэ ганц хөтөлбөрөөр ингэж явж байгаа юм уу, яаж байгаа юм гэдгийг би тодруулж асуух гэсэн юм.

Ч.Ундрам: Би яг энэ Хэрлэн гишүүнтэй адилхан асуулт асуух гээд энэ бүхэл бүтэн жилийн ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүхэл бүтэн нэг яамны нэг том чиг үүрэгтэй холбоотой 21 аймаг, 9 дүүрэгтэй холбоотой соёлын асуудал дээр ганцхан ажил хийх юм бол энэ яам чинь өөр юу хийх юм бэ гэдэг ийм асуулт байгаа. Номин сайд хариулъя.

Ч.Номин: Хэрлэн гишүүн Ундррам гишүүн 2-ын асуултад хариулъя. Гишүүдтэй санал нэг байна. Манай Соёлын яамны хувьд үндсэн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үндсэн чиг үүргийнхээ ажлыг хэрэгжүүлэх хүрээндээ 30 гаруй хөтөлбөр ажлыг санал болгосон. Үүнээс нэг ойролцоогоор 7, 8 нь орж ирсэн байгаа. Тэгээд яг энд манай соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалт, бүх нийтийн соёлын боловсрол, дээрээс нь соёл урлагийг хөгжүүлэх, залуучуудын чиглэлээр тусгах шаардлагатай хөтөлбөр, арга хэмжээ буюу чиг үүргийн ажлууд маань бүрэн тусгагдаагүй байгаа. Тэгэхээр үүнийг ингэж нэг бүрчлэн заалт заалтаар гэхээс илүүтэй яг Байнгын хороон дээрээс албан ёсоор ажлын хэсэгт чиг үүрэг болгож өгүүлмээр байна.

Тэр нь юу вэ гэхээр энэ соёлын өв, бүх нийтийн соёлын боловсрол, соёл урлагийг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх ажилтай залуучуудын чиглэлийн ажлуудыг бүрэн хэмжээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан тусгуулах энэ саналыг гаргаж өгөөч гэдэг хүсэлт байна. Яамны зүгээс энэ хэмжээнд тусгагдсан одоо байгаа хүрээнд үйл ажиллагаагаа бүрэн явуулах боломжгүй гэж үзэж байгаа. Бидний хувьд мэдээж хэд хэдэн удаагийн удаа энэ ажлуудаа нэрээр нь, хөтөлбөрөөр нь, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдлаар нь саналаа өгөөд байгаа гэдгээ хэлье.

Ч.Ундрам: Энэ төлөвлөгөө чинь Эдийн засаг, хөгжлийн яаман дээр нэгтгэгдэж байгаа шүү дээ. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү энэтэй холбоотой ямар тайлбар байна вэ? 3 номерын микрофоныг өгөөрэй.

И.Батхүү: Хэрлэн гишүүн, Ундррам гишүүний асуултад хариулъя. Энэ холбогдох яамдаас нэг сараас эхлээд бид улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбоотой төсөл, арга хэмжээний санал авч эхэлсэн байгаа. Тэгээд манай яамны ажлын хэсгүүд яамнуудтай цуг суугаад, холбогдох хуулийн шаардлага, батлагдсан аргачлалын дагуу аль төсөл арга хэмжээнд суух боломжтой юм бэ гэдэг дээр хамтарч ажилласан. Тэрний дагуу нэгтгэгдэж орж ирсэн төсөл байгаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ч гэсэн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гэж батлагдсан жил жилээрээ хүрэх түвшинтэй баримт бичгийг ЗГ дээр батлагдсан байгаа энэнийхээ дагуу. Мөн яамны үндсэн үйл ажиллагаа, урсгал зардлынхаа хүрээнд тодорхой арга хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой. Дээр нь нэмээд одоогийн байдлаар төсөлд тусгагдаагүй байгаа арга хэмжээнүүдийг Байнгын хорооны дэгийн дагуу зарчмын зөрүүтэй саналаар оруулах боломжтой байгаа.

Ч.Ундрам: Түрүүн Номин сайдын хэлж байгааг сонсохоор хамтарч ажиллаагүй юм шиг л танайх цавчаад хасчихсан юм шиг л надад харагдаад байна л даа. Тэгээд сая энэ олон улсын хуралд яваад ирэхэд тэнд хүмүүс ярьж байна. Танай эдийн засгийг солонгоруулъя, Монгол бүтээгдэхүүнээ нүүрс уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүнээ гадаадад экспортольё гэвэл соёлыг шингээсэн ийм бүтээгдэхүүн байж л зарагдана. Ингэж байж эдийн засаг чинь солонгорно. Жишээлбэл ХҮ хамтлаг ч гэдэг юм уу ийм Монгол өв соёлыг тээж байгаа ийм онцлогтой энүүгээрээ л бид ялгарч дэлхийн зах зээлд орох юм байна гэдэг асуудлыг олон улсын судлаачид, бизнес эрхлэгчид бүгд ярьж байна. Cashmer-аа заръя гэвэл бас л энэ Монгол өв соёлоо шингээсэн байдалтай бүтээгдэхүүн байж л зарагдана. Тэрнээс яг Европтой адилхан юм хийгээд тэр том зах зээл дээр очоод өрсөлдөх ямар ч боломжгүй гэж яриад байгаа байгаа байхгүй юу.

Гэтэл энд бид ЗГ нь өөрөө төлөвлөгөөгөө оруулж ирэхдээ энэ салбараа хасчхаад, тэгээд эдийн засаг солонгоруулмаар байна гэж яриад байх юм бол энэ чинь ерөөсөө зөрчилдөөнтэй ингэж харагдаад байна л даа. Тийм учраас манай энэ БСШУС-ын байнгын хороо энэ дээр гишүүд маань нэлээн анхаарах ёстой гэж бодож байна. Энэ асуулт асуух хүмүүсийн нэрсэнд Бум-Очир гишүүний нэрсийг оруулчхаарай. Асуулт, хариулт хангалттай юу Хэрлэн гишүүн? Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: 2 асуулт байна. 1 дүгээрт нь би нөгөө конвенц гэрээ яриад яваад байгаа. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний ер нь хөгжлийн төлөөх зорилтот төслүүдийнхээ 15 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог дэмжихэд агуулгатай төслүүдэд зориулна гэдэг ийм олон улсын тунхагт Монгол Улс нээгдсэн. Берлинд сая. Ингээд үзэхээр төсвийн ерөнхийлөн захирагчид бүгдээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог дэмжиж байгаа нь энэ юм гэдэг агуулгатай ажлуудаа тусад нь нэг багана болгож мэдээлэх, ялгаж салгах, хэмжих ийм шаардлага бий болж байгаа. Тэгэхээр танай яг энэ яамны хувьд жишээлбэл яг энэ дээр ямар төлөвлөгөө гарсан юм бэ? Би ингээд нөгөө харахлаар тухайлсан юм харсангүй. Энэ дээр мэдээлэл авмаар байна.

2-т болохоор биеийн тамир спортын тухай асуудлыг бид ярих цаг болсон. Яагаад гэвэл одоогийн манай биеийн тамир спортын хууль, эрх зүйн зохицуулалтыг харахлаар үндэсний баяр наадамтай холбоотой бөхийн асуудлууд, тэгээд эсвэл нөгөө олимп, паралимпын асуудлууд яригдаж байгаа. Нийгмийн эрүүл мэндийн хуулиа харвал хүнийг эрүүл, аюулгүй амьдруулах, урт наслах хамгийн чухал хүчин зүйл биеийн тамир, спорт байдаг. Өөрөөр хэлбэл бүх нийтийн гүйлт, алхалт байгаа. Тэгэхээр бүх нийтийн гүйлт, алхалтыг дэмжихтэй холбоотой дүүрэг болгонд ямаршуу ажил энэ тусгагдсан юм бэ? Би яг энэ үгээрээ хайхаар нөгөө зузаан материалаасаа хайж олж чадахгүй л байгаад байна. Тэгэхээр жишээлбэл яг ийм мэдээлэл байвал зүгээр. Энэ 2025, 26, 7 онд иргэдийн гүйх цэцэрлэгт хүрээлэн орчин нэг ийм байх юм. Энэ дээр манай яамны оролцоо ийм байна гэдэг юм уу, сургуулийн биеийн тамирын хичээлүүдийг ингэж сайжруулах юм гэдэг юм уу. Ялангуяа бүх нийтийг биеийн тамиржуулахад Соёлын яамны төлөвлөгөө дотор соёл, боловсролын энэ том багц дотор юу юу байна вэ гэдэг дээр нарийвчлан авъя. Нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог дэмжихтэй холбоотой ажлууд.

Ч.Ундрам: Эхний асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү хариулъя, 3 номер микрофон.

И.Батхүү: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Яг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд 2.11.1 дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймгуудад байгуулах гэдэг арга хэмжээ туссан байгаа. Ер нь жендерийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд авах арга хэмжээний асуудал бүх салбар хариуцсан дамнасан нийтлэг асуудал байгаа. Энд төрийн бүх байгууллагууд энэ дээр анхаарч ажиллах ёстой. Төрийн бүх байгууллагуудын урсгал зардал, үйл ажиллагааны зардал дээр энэ асуудлууд тусаад явах ёстой гэж үзэж байгаа. Энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр ихэвчлэн хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээнүүдийг нь тусгасан байгаа. Урсгал зардал, үйл ажиллагааны зардлаар явагдах ажлууд маань ирэх намар улсын төсөв хэлэлцэхэд яг арга хэмжээгээрээ тусаад явна.

Ч.Ундрам: 2 дугаар асуултад 6 номерын микрофон Оюунбилэг.

С.Оюунбилэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэд өгөгдлийг ТНБД чиг үүргийнхээ дагуу хариуцаж байгаа. Бид чиг үүргийнхээ дагуу дэд зөвлөлөө хуралдуулаад, жилийн ажлын төлөвлөгөөгөө баталсан. Манай салбарын хувьд яг тусгайлан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тусгайлан авч үзэх нь ялгаварлан гадуурхалтын нэг шинж юм гэж үздэг. Мөн гишүүд маань ийм саналыг удаа дараалан хэлж байгаа учраас бүх соёл урлаг, биеийн тамир, залуучууд, соёлын өвийнхөө үйл ажиллагаандаа бүгдэд нь яг хуульд заасан чиг үүргийнхээ дагуу агуулгынх нь хувьд шингээгээд, энэ үйл ажиллагаандаа хамруулаад жил бүрийнхээ тайланд илтгээд явдаг. Энэ дагуу 2026 оны манай чиг үүргийн бүхий л ажлуудад энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ тэгш хүртээмжтэй хамруулах ажлууд маань тусгагдсан. Тэгэхээр танд тусгайлан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ зөвлөлийн ажлын төлөвлөгөөгөө хүргүүлъя гэж бодож байна. Таны чухал асуудлыг хэлж байна. Бүх нийтийн биеийн тамир маш чухал. Өнгөрсөн хугацаанд бид илүү мэргэжлийн спорт болон олимпын төрөл рүүгээ анхаараад.../минут дуусав/

Ч.Ундрам: 6 номерт нэмэлт минут өгье.

С.Оюунбилэг: Ингэж ажиллаж ирсэн байгаа. Одоо манай сайдын барьж байгаа гол бодлого бол бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, биеийн тамирын бүх иргэдийг биеийн тамирт тэгш хамруулах ажлуудыг зохион байгуулах ийм бодлого стратеги гарч байгаа. Таны 2.8.2 дээр хүн амын идэвхтэй хөдөлгөөн спортын мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна гэдэг зорилтын хүрээнд байгаа тэр сорилын төвүүд бол бүх нийтийн биеийн тамирт хамруулах энэ үйл ажиллагааг бүрэн утгаар нь улсын хэмжээнд хэрэгжүүлэх энэ үйл ажиллагаанууд туссан байгаа.

Ч.Ундрам: Хариулт хангалттай юу? Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Яах вэ ингээд иргэд ерөөсөө ингэж л асуудаг юм байна лээ. Биеийн тамирын талаар ярихад жишээлбэл сайн дурын үндсэн дээр өөрсдөө байгуулагдсан гүйлтийн холбоод байгаа. Улаанбаатар марафон маань зохион байгуулагдаж байна. Маш олон сайн дураараа нэгдсэн хүмүүс өөрсдийнхөө бор зүрхээрээ л гүйлтээ хийгээд явж байгаа. Энэ нь өөрөө төр засагтайгаа хамтран ажиллах гэхлээр маш их асуудалтай байдаг. Тэгэхээр биеийн тамирыг дэмжинэ гэдэг нь нэг заалны асуудал биш байгаад байгаа, нэг байшин ч юм уу. Тэр заал, байшин чинь өөрөө урсгал зардалтай. Дараа нь тэр лүү нь орох гэж бөөн ачааллууд байдаг. Тэгэхээр энэнээс илүүгээр ер нь нийтийн энэ биеийн тамирыг хөгжүүлж байгаа байгууллагуудтай хамтын ажиллагааны хувьд манайх ингэнэ, ингэнэ гэдэг нь илүү тэд нарын хувьд амьдралд ойр санагдах болов уу гэж бодож байна. Байшин барилгын зардлаас илүү. Тэгэхээр энэ талаас нь тайлбар хүсээд байгаа юм. Хөгжлийн бэрхшээл дээр бол яг ингэж яриад, дараа нь ярина шүү гээд дараа нь ярихаар эрт ярихгүй байсан юм гэдэг асуудал гардаг шүү. Тэгэхээр заавал эрт л оруулсан оруулсан тоотой л, 15 хувь гэдэг тоогоо л барих хэрэгтэй. Яах вэ орсон байгааг.../минут дуусав/

Ч.Ундрам: Тодруулга асуултад Номин сайд хариулт өгье.

Ч.Номин: Саранчулуун гишүүнээ ер нь нийтийн биеийн тамир гэдэг нэг чигтээ төрөөс аль нэг ажлыг албадан шаардаж хийх боломжгүй зүйлүүд байдаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Нийтийн биеийн тамир гэдэг тухайн хүний амьдралын хэв маягт суулгах шаардлагатай зүйл. Тийм учраас бид илүүтэй иргэдийг соён гэгээрүүлэх, мэдээллээр хангах зүйл дээр анхаарах нь чухал. Нөгөө талдаа биеийн тамирыг хөгжүүлнэ гэдэг хамгийн чухал зүйл юутай байдаг вэ гэхээр мэргэжлийн спортын холбоодтой хамтарч ажиллах байдаг. Тэгэхээр бидний хувьд мэргэжлийн спортын холбоодтой хамтарч ажиллаад, энэ хүрээндээ нийтийн биеийн тамирыг илүү түлхүү хөгжүүлэх, дээрээс нь спортын олон төрлийг Монголд хөгжүүлэх дээр анхаарч ажиллаж байгаа. Тэгэхээр таны хэлээд байгаа дан ганц олимпын төрлүүд гэхээсээ илүүтэй хүүхэд, залуучуудын сонирхож байгаа өөрсдийнх нь спортоор дамжуулан нийтийн биеийн тамирыг буюу амьдралын хэв маяг сайжруулах дээр холбоодтой нь хамтарч ажиллах ажлыг хийнэ. Мэдээж төсөв санхүү хязгаартай учраас бид хамтарч ажиллахдаа аль болох.../минут дуусав/

Ч.Ундрам: Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Эхний асуулт энэ их сургуулиудтай холбоотой асуулт байгаа. Хуулиараа Боловсролын ерөнхий хууль дээр Судалгааны их сургуулийн тухай хуулийг ЗГ өргөн барина гэсэн байгаа. Тэгээд энэ чиглэлээр ямар ажил хийгдэж байна вэ? 26 онд энэ Судалгааны их сургуулийн тухай хууль орж ирэх үү 1 дүгээрт?

2 дугаарт энэ их сургууль маань ер нь шинжлэх ухааны байгууллага мөн юм уу, биш юм уу гэдэг асуултыг та бүхнээс асуумаар байна? Эдийн засаг, хөгжлийн яаман дээр шинжлэх ухааны салбарууд байгаа. Боловсролын яамныхан байна. Одоогийн байгаа хууль, эрх зүйн орчноор их сургуулиудыг шинжлэх ухааны байгууллага гэж үзэхгүй байх шиг байгаад байгаа юм. Шинжлэх ухаан, технологийн хууль дээр холбогдох байгууллага гэдэг дээр Шинжлэх ухааны академи байгаа болохоос биш их сургуулиуд байхгүй байгаа. Энэ төлөвлөгөө энэ тэр юмнуудыг хараад байхаар их сургууль дээр байгаа эрдэм шинжилгээний байгууллагууд, хүрээлэнгүүдийг нь эрдэм шинжилгээний байгууллага гэж үзээд, их сургуулийг нь өөрийг нь эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллага гэж үзэхгүй байгаа юм шиг юм харагдаад байгаа юм. Тэгэхээр энийгээ бид нэг тийш нь болгохгүй бол их сургуулийг шинжлэх ухааны байгууллага гэж үзэхгүй юм бол бид нөгөө их сургуулиудаа дэлхийн шилдэг эрэмбийн жагсаалтад оруулах энэ тэр асуудал чинь бүрэн хэрэгжиж чадахгүй гэдгийг хэлэх гэсэн юм.

Би миний авсан мэдээллээр Эдийн засгийн хөгжлийн яаман дээр шинжлэх ухааны хариуцсан газар дээр их сургуулиудыг шинжлэх ухааны байгууллага болгох гэж юу гэдэг юм тодорхойлох судалгаа, бэлтгэл ажлууд хийгдэж байгаа гэж би сонссон. Баттогтох дарга ирчихсэн байна энийг хариуцаж байгаа болов уу гэж ойлгож байна. Энэ ажил хэр их явж байна вэ? Ер нь энэ их сургуулиудаа шинжлэх ухааны байгууллага гэхгүй бол би өөрөө их сургуулийн багш байсан хүн. Би бүх насаараа шинжлэх ухааны ажил хийсэн гэж өөрийгөө бодож явдаг байхгүй юу. Тэр олон багш нар чинь ялгаагүй ингэж бодож байгаа. Ундрам гишүүн ялгаагүй Байнгын хорооны дарга. Тэгэхээр энэ чинь шинжлэх ухааны байгууллага биш гэж үзвэл шинжлэх ухаантай холбоотой судалгаа, шинжилгээ бүх юмнаас энэ их сургуулиуд чинь хасагдаад байхаас гадна, бид энэ их сургуулиудаа шинжлэх ухааны байгууллага гэж үзэхгүй юм бол Монгол ганцхан шинжлэх ухааны

байгууллагатай болж харагдана. Тэр нь Шинжлэх ухааны академи. Энэ нь гэтэл Орос, Монгол, Хятад 3-д голдуу байдаг тогтолцоо. Жишээ нь British academy буюу Британийн академи гэдэг бол яг шинжлэх ухааны байгууллага биш, шинжлэх ухааны байгууллагыг дэмждэг менежментийг нь хийдэг байгууллага шүү дээ. Нэг ийм юмнууд байгаад байгаа 1 дүгээр зүйл.

Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр маш олон сургууль, цэцэрлэгийн дутагдал байгаа, багшийн дутагдал байгаа. 777 багшаар нэмэгдсэн энэ тэр гэсэн төлөвлөгөө байна. Тэгээд Боловсролын яамнаас тодруулмаар байна. Энэ багшийнхаа хүрэлцээг цаашид яаж нэмэх гэж байгаа юм бэ? Нөгөө 45 хоногийн курс маань тэгээд хэдэн миний ойлгосноор тэр курс маань энэ дутагдлыг нөхөж чадна гэж би бол бодохгүй байгаа. Тэгэхээр цаашдаа ялангуяа 26 оныг боловсролын жил болгон зарлаж байгаа. Тэгэхээр бид энэ хүрээнд хамгийн бидний хийх шаардлагатай зүйл бол энэ дутуу байгаа сургууль, цэцэрлэгүүдээ яаралтай барих. Миний ойлгосноор 26 оны төсөвт сургуулиуд суусан байгаа. 28 он хүртэл, түүнээс гадна дахиад 108 сургууль, 95 цэцэрлэг энэ тэр хэрэгтэй байгаа юм шиг байна лээ. Энэ Галбадрах багш, Галбадрах гишүүн энэ дээр тоо энэ тэр юмаа хэлээд ярих байх. Энэ төлөвлөгөө харагдахгүй байгаад байх юм бидэнд ирсэн энэ материал дээрээс.

Тэгэхээр бид ямар төсвөөрөө, яаж энэ дутуу байгаа сургууль, цэцэрлэгүүдээ барих юм бэ, мөн дутуу байгаа багш нараа яаж нөхөх юм бэ? Энэ маш яаралтай тулгамдчихсан асуудал шүү дээ. Үүний цаана нь боловсролын чанарын асуудал байгаа. Үүний цаана хүүхдүүдийн боловсрол, хүмүүжил, төлөвшил буюу ирээдүйн Монгол Улсын иргэдийг чанартайгаар бэлтгэх асуудал байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бидний ойлгож байгаагаар ялангуяа манай Байнгын хорооны хувьд хамгийн тулгамдсан асуудлуудын нэг гэж бодож байгаа. Энийгээ бид хэзээ энэ дутагдлаасаа арилгах юм бэ гэдгийг тодруулж өгөөч. Баярлалаа.

Ч.Ундрам: Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Баттогтох 5 номерын микрофон, 1 дээр суучихсан байна шүү дээ. 1 номер.

Д.Баттогтох: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 24 онд шинэчилж, шинэчилсэн найруулгаар батлагдсан Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлээр эрдэм шинжилгээний байгууллагуудыг тодорхойлсон байгаа. Тэгээд энэ хуульд эрдэм шинжилгээний байгууллагад хамаарах дараах байгууллагыг тооцно гэж үзэж байгаа юм. Энд мэдээж хүрээлэн төв байна 1 дүгээрт, 2 дугаарт дээд боловсролын холбогдох заалтаар зохицуулсан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллагыг мөн хамааруулж болно. Шинжлэх ухаан технологийн үйлдвэрлэлийн нэгдэл энэ байгууллагад хамаарна. Дээр нь төрийн болон орон нутгийн музей бол эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулж болно гэсэн ийм зохицуулалттай байгаа.

Тэгэхээр Дээд боловсролын тухай хуулиараа тухайн байгууллагыг тодорхойлсон. Музейн тухай хуулиараа музейн байгууллагыг тодорхойлсон байгаа. Тэгэхээр бид ер нь гишүүний асуултад хариулахад дээд боловсролын байгууллага бол эрдэм шинжилгээний байгууллагад тооцогдоно. Гэхдээ тодорхой шалгуур үзүүлэлтийг хангаж тооцогдох ёстой. Энэ зохицуулалт нь Шинжлэх ухаан, технологийн хуулийн 18.6 дээр мөн туссан байгаа. Шинжлэх ухааны асуудал

хариуцсан ЗГ-ын гишүүн холбогдох шалгуур үзүүлэлтийг батлаад, тэгээд энэ хүрээндээ эрдэм шинжилгээний байгууллагын статуст хамрагдаад явах бүрэн бололцоотой байгаа юм. Тэгээд яагаад тэгж байгаа юм гэхээр ер нь мэдээж их сургуулиуд ялангуяа төрийн өмчийн их сургуулиуд бол энэ статус эрдэм шинжилгээний байгууллагын шаардлагаа бүрэн хангах бололцоотой. Тэр нь ч харагдаж байгаа.

Цаашлаад ингээд хувийн хэвшлийн сургуулиуд гээд эрдэм шинжилгээний байгууллагын статус авахад бид тодорхой шалгуур, стандартыг барьж явахгүй бол болохгүй байгаа юм. Лаборатори, мөн судалгаа хөгжүүлэлтийн зардалд нэгж багшид ноогдож байгаа гэх мэт, бүтээлийн тоо нэгж багшид ноогдож байгаа гээд энэ бүх зүйлүүдээ баримталж явахгүй болохгүй байгаа юм. Энэ хүрээндээ Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас хүсэлтүүд ирээд, холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийгдээд, энэ 2 сургууль сайдын тушаалаар эрдэм шинжилгээний байгууллагын статусаа бүрэн авсан байгаа юм. Одоо Соёл урлагийн их сургууль болоод Монгол Улсын багшийн их сургуулиуд хүсэлтээ өгсөн. Энэ дээр ажлын хэсэг ажиллаад, холбогдох статусын баталгаажуулаад явахаар байгаа.

Ч.Ундрам: Боловсролын яамны ТНБД Батжаргал 6 номерын микрофон.

Х.Батжаргал: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Судалгааны их сургуулийн тухай хууль болон судалгааны их сургуулийг байгуулах асуудал ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссаны дагуу үйл ажиллагаа Боловсролын яаман дээр үндсэн урсгал зардлынхаа хүрээнд явагдаж байгаа Хууль тогтоомжийн тухай хуулийн процессын дагуу. Тухайлбал суурь судалгаанууд хийгдэж байгаа. Тэгээд 2026 оны түвшинд энэ дээр үндсэн 26 оны энэ хөгжлийн бодлого дээр туссан Азийн хөгжлийн банкны санхүүжилт зээлийн арга хэмжээ байгаа. Тэгээд түүнд туссаны дагуу хамтын ажиллагааны хүрээнд нэлээн нарийвчилсан, дэлгэрэнгүй, томоохон ажил өрнүүлж, энэ ажлаа эрчимжүүлээд 26 онд хуулийн төслийг оруулахаар төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа.

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд томоохон 2, хүртээмж болон чанарыг нэмэгдүүлэх ажлын хэсгүүд гаран ажиллаж.../минут дуусав/

Ч.Ундрам: 6 номерт минут нэмж өгье.

Х.Батжаргал: Энэ хүрээндээ ер нь хэрэгцээ шаардлагыг тодорхойлоод, 108 сургууль ерөнхий боловсролын, 95 цэцэрлэг гэсэн тийм тоо хэрэгцээг хүн амын өсөлт, динамик өсөлттэй уялдуулж гаргасан байгаа юм. Түүний 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд ямар ч байсан 45 сургууль, 45 цэцэрлэг гэж тусгаж, төлөвлөж оруулж ирж байгаа. Тэгээд энэ хүрээндээ залгаад төсвийн боловсруулалтын түвшинд хүртэл ингээд оролцогч талуудын оролцоотойгоор ажлын хэсгүүддээ бүр нарийвчлаад байршил, тэгээд шаардлага хангасан бүхий л түвшний арга хэмжээг авч ажиллахаар байгаа. Таны асууж байгаа гол асуудал мөн яах аргагүй багшийн хэрэгцээ шаардлага энэ өсөн нэмэгдэж байгаа сургууль, цэцэрлэгийг дагаад багшийн асуудал байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ ЗГ-аас багшийн 3 тулгуурт бодлогыг батлаад хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Хөгжлийн төлөвлөгөөнд энэ.../минут дуусав/

Ч.Ундрам: Бум-Очир гишүүн тодруулъя.

Д.Бум-Очир: Баярлалаа. Нэгд энэ эрдэм шинжилгээний байгууллага, шинжлэх ухааны байгууллага гэдэг 2 нэр томьёо явж байгаа. Би эрдэм шинжилгээний таны Баттогтох даргын сая тайлбарлаж байгааг ойлголоо. Тэр шалгуур үзүүлэлт энэ тэр юмнууд байлгүй яах вэ. Гэхдээ эрдэм шинжилгээний байгууллага гэж явчхаад байгаа юм. Яг шинжлэх ухааны гэж нэрлэх ёстой юм биш үү? Би бол шинжлэх ухаан, боловсролын байгууллага гэж их сургуулиудаа нэрлэмээр байгаа байхгүй юу. Эрдэм шинжилгээ гэдэг маань яг шинжлэх ухаан гэсэн үгнээсээ утга агуулгын хувьд арай зөрөөтэй юм уу, арай доод түвшний нэр юм шиг харагдаад байгаа юм. Эрдэм шинжилгээний ажил хийдэг зөндөө байгууллагууд байж болно. Тэд нарыг шууд шинжлэх ухааны байгууллага гэж үзэх үү, үгүй юү гэдэг нэг ийм асуудал байгаад байгаа. Манай хууль дээр ийм 2 нэр томьёо яваад, шинжлэх ухааны байгууллага биш ээ, эрдэм шинжилгээний байгууллага гээд үзчихэж байгаа нь шинжлэх ухааны байгууллага гэж үзсэнтэй дүйцэх үү, үгүй юү гэдэг асуудал болчхоод байгаа байхгүй юу. Миний ойлгож байгаагаар дүйцэхгүй юм шиг харагдаад байгаа юм.

Ч.Ундрам: 1 номерын микрофон Баттогтох дарга.

Д.Баттогтох: Өмнөх 2006 онд орсон өөрчлөлт манай суурь хууль болох Шинжлэх ухаан, технологийн хууль дээр иймэрхүү зохицуулалт байсан. Сая 24 онд бид зөвхөн нэг тодорхойлолтоор авч явсан. Эрдэм шинжилгээний байгууллага гэж судалгаа хөгжүүлэлтийн ажлыг дагнан эсхүл сургалт үйлдвэрлэлтэй хамт эрхэлдэг хуулийн этгээдийг хэлнэ гээд томьёолсон байгаа. Мөн аж ахуйн нэгжтэй холбоотой зохицуулалт байгаа. Тэгэхээр ер нь эрдэм шинжилгээний байгууллага гэдгээрээ явж байгаа. Яах вэ олон улсдаа яг нөгөө research institut гэдэг маягаар хэрэглэдэг учраас scientific organization гэх орчуулга нь илүү судалгааны институт гэдэг уг нь илүү нийтлэг байдаг учраас бид энэ томьёоллыг аваад явсан. Тэгэхдээ мэдээж та тийм зарчмын зөрүүтэй санал, одоо зарим нэг гишүүд үндсэн.../минут дуусав/

Ч.Ундрам: Ер нь энэ шинжлэх ухааны байгууллагын асуудал чинь яг их сургууль дээр ингээд хоёрдмол 2 яамны харьяа ч юм шиг ингээд ийм сонин болчхоод байна л даа. Тэгээд их сургууль ер нь л судалгааны, судалгаа, сургалтын байгууллага байх ёстой. Тэгээд заавал Эдийн засаг, хөгжлийн яаман дээр энэ боол шинжлэх ухааны байгууллага мөн юм гэж сайдын тушаалаар тодорхойлогддог ийм субъект биш шүү дээ. Тэгээд та хэд заавал заримыг нь хамж аваад, заримыг нь цааш нь түлхээд ингээд байгаад байгааг чинь ч ер нь ойлгохгүй байна. Бид анх ЗГ-ын бүтэц ярьж байхад л энэ асуудлыг ярьж байсан.

Тэгээд яах вэ хэдийгээр шинжлэх ухааны инновацын асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаад явж байгаа ч гэсэн та бүхэн үйл ажиллагаандаа их сургуулиудаа хамруулаад, Боловсролын яам дээд боловсролын асуудлаар ингээд хамруулаад зарим юман дээрээ хамтраад ингээд уялдаатай явах нь зөв байх гэж би бодож байна. Зүгээр ЗГ-ын бүтэц ийм байдалтай хийгдсэнээс болоод энэ Монгол Улсын шинжлэх ухааны болон дээд боловсролын асуудлыг нэг их 2 хуваах гээд байгаа юм шиг ийм 2 талт бодлого явж болохгүй. ЗГ чинь угаасаа нэгдмэл нэг ийм байгууллага учраас тийм хандлагын л асуудал байгаа юм шиг надад харагдаад байгаа шүү. Тэгээд нөгөө их сургуулиуд нь нэгэнд нь заавал ингээд бүтнээрээ харьяалагдах гээд бас тэгж үзээд байгаа нь ч гэсэн буруу байгаа

байхгүй юу. Заавал нэг юманд ингээд харьяалагдаад л ганцхан эндээ байна гэдэг тийм ойлголт биш шүү дээ.

Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам илүү энэ их, дээд сургууль дээрээ гарч байгаа инновац, шинэ бүтээгдэхүүнээ эдийн засгийнхаа салбарууд руу ойртуулж өгье л гэсэн ийм бодлого тэнд явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд энийгээ дээд сургуулиуддаа сайн ойлгуулаад, заавал сайдын тушаал гаргаад л чи мөн, чи биш гэхгүйгээр ерөнхий ийм бодлого гаргаж явах нь зүйтэй юм шиг санагдаж байна Байнгын хорооны хорооны даргын хувьд. Энэ нөгөө асуулт асуух гишүүдийн нэрст Галбадрах гишүүний нэрийг оруулъя. Тэгээд Хосбаяр гишүүн асуултаа асууя.

Г.Хосбаяр: 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгоод зарлачихсан байгаа. Тэгээд энэ ажлын хүрээнд боловсролын чанар, хүртээмж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ гээд оруулсан байгаа. Тэгээд сургууль, цэцэрлэг болохоор 108 сургууль, 95 цэцэрлэг барина, стандартын түвшинд хүргэнэ гэсэн байна л даа. Тэгэхээр 26 онд эхэлнэ гэж ойлгож байна. Тэгээд улсын төсөв дээр нэлээн ачаалал ирэх байх шинэ сургууль, цэцэрлэг бараг 200 гаруй сургууль, цэцэрлэг барих нь л дээ. Тэгэхээр бид чинь нөгөө өмнөх олон жил ярьж байгаа сургууль, цэцэрлэгийн барилга уддаг гээд. Тэгээд ер нь энэ нэг олон нийтийн барилгынхаа стандартыг Барилга, хот байгуулалтын яам, энэ яамнууд хоорондоо уялдаж яриад, стандартуудаа шинэчлээд, нэг маягийн зурагтай болоод, мөн ер нь тэр сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгыг хурдан барих боломж бололцоо, шинэ технологи судалж байгаа ийм зүйл ер нь байна уу?

Саяхан Хятадад угсармал технологиор 20 давхар барилгыг нэг өдөрт бариад ашиглалтад оруулж байгаа тухай мэдээнүүд явж байна. Барилгын технологи юмнууд сайжирч байна, өөрчлөгдөж байна. Ер нь нэг хөрөнгө мөнгөний хувьд ч хэмнэлттэй, хурдан түргэн хугацаанд барих ийм боломжууд, ийм технологи, ийм материалууд гараад ирчихсэн л дээ. Тэгэхээр энийг ер нь судалгаа шинжилгээ хийж байгаа юм байна уу? Тэгэхгүй бол дахиад л 200 гаруй сургууль, цэцэрлэгтэй бид хэдэн жил л ноцолдох байх л даа. Тэгээд сүүлд нь үнэ өссөн гээд л, зарим нь дуусгаж чадахгүй гээд л ингээд л асуудал үүсэх байх. Тэгэхээр энэ сургууль, цэцэрлэгийн барилгын 1 дүгээрт нь тэр зураг, төсөл стандарт, хурдан түргэн барих тал дээр судалгаа шинжилгээ байна уу?

2 дугаарт нь нэг маягийн зурагтай байгаад бас энэ хувийн хэвшлийнхээ хөрөнгө оруулалт, хувийн, төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ асуудал дээр л онцгой анхаарч ажилламаар байна л даа. Тэр хууль нь орж ирэх гэж байгаа гээд тэгж байсан. Тэгээд сая чинь уг нь 2 жилийн өмнө Энх-Амгалан сайдын үед хувийн хэвшилтэйгээ түншлээд л нэлээн олон Улаанбаатар цэцэрлэгийн асуудал шийдсэн, түрээсэлсэн гээд ингээд ярьдаг. Тэгэхээр яг энэ дээр дорвитой хийсэн судалгаа байна уу, ер нь хувийн хэвшлийнхээ нөөц боломжийг ашиглахгүй юм уу гэдэг юмыг би дахин, дахин яриад байгаа. Хувийн хэвшил чинь борлуулалт нь буурчихсан, орон сууц барьцаагаад л байдаг. Тэгтэл уг нь ингээд төртэйгөө түншлээд, хурдан түргэн хаана хаанаа ашигтай хувилбараар хийвэл 200 сургууль, цэцэрлэгийг Монголын барилгачид нэг жилийн дотор л барьчихна даа. Энэ их жилд 19, 20 мянган айлын орон сууц барьж байгаа барилгачид дор нь л барьчих, хийчих ажил байгаа. Тэгээд энэ дээр нэг тийм зоригтой өөрчлөлт нэг тийм бодлогын арга хэмжээ авбал яадаг юм бэ л гэсэн ийм санал байгаа.

Тэгээд нөгөө төр, хувийн хэвшлийн түншлэл гэхээр л өртөг мөнгөний асуудал ярьдаг. Тэртээ тэргүй л дэлхий нийтэд жил ирэх тусам бүтээн байгуулалтын зардал нэмэгдэж байгаа шүү дээ. Энэ жил 10 тэрбумаар барих сургуулийг 2 жилийн дараа 12 тэрбумаар л барина, дахиад 2 жилийн дараа 28 онд 14 тэрбум л болно хүссэн, хүсээгүй, тэртээ тэргүй энэ дэлхий нийтэд бүтээн байгуулалтын зардал өсөж байхад. Тэгэхээр түрүүлж хийгээд, энэ хүртээмжээ сайжруулаад, хувийн хэвшлийнхээ боломж, бололцоог ашиглаад ингээд явах юман дээр ер нь Эдийн засаг, хөгжлийн яам ямар санаачилгатай ажилладаг юм бэ гээд.

Дараа нь аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт нэлээд их хийх шаардлага байгаа. Тэгээд Номин сайд өнөөдөр ярьсан байсан бага хүүтэй зээл хувийн хэвшилд олгоно банкнуудаар дамжуулж гээд. Тэгээд миний олж сонссоноор 50 тэрбум төгрөгийн эх үүсвэр байгаа юм шиг байна лээ. Тэгээд тэр нь яг энэ аялал жуулчлалын салбарт хаанаа ч хүрэхгүй л дээ. Тэгээд бүр олон жижиглээд өгвөл дорвитой хөрөнгө оруулалт болохгүй нэг хэдэн жуулчны баазад хуваагаад өгчихвөл жорлон хийсэн гээд ингээд л.../минут дуусав/

Ч.Ундрам: Эхний асуултад эхлээд Боловсролын яам Батжаргал дарга хариулъя, 6 номер.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Батжаргал. Гишүүний асуусанчлан энэ сургууль, цэцэрлэгийн барилгын бүтээн байгуулалт барилгын явцад маш их хугацаа алддаг өнгөрсөн жилүүдэд. Ялангуяа энэ бараг арваад жил ч үргэлжилчихсэн ийм асуудлууд байдаг. Зүгээр гол шалтгаан нь юу вэ гээд бид Сангийн яамтайгаа ажлын хэсгийн түвшинд ингээд аваад үзэхээр зэрэг зураг төсөлгүй барилга төсөвт батлагдаж явах, тэгээд зураг төсөл нь батлагдаад гараад ирэхээр зэрэг төсөв нь нэмэгддэг, магадлалаар ингээд үе шаттайгаар нэмэгдэх энэ бүх процесс нь өөрөө маш их хугацаа авчихсан ийм асуудал байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ өнгөрсөн хугацааны сургамжаас бид ямар ч байсаниж бүрэн зурагтай, тэгээд нөгөө жишиг зургийг бид бариад явахаар холболтын асуудал гарч ирдэг. Дэд бүтцийн холболтын асуудал. Тэрийг ч гэсэн ер нь урьдчилж тодорхой болгож байж ингээд шийдвэл барилгын компаниудын хувьд энэ нэг хурдны хувьд тэгж 2, 3 жил орохоор асуудал биш юм байна лээ. Тэгээд бид энэ санхүүгийн төлөвлөлтөө ч гэсэн Сангийн яамтайгаа уялдаад хамтраад энэ төлөвлөлтийг хийж байгаа. Жишиг зургийн тухайд бүх төрлийн жишиг зургууд гарч байгаа. Эдийн засаг, хөгжлийн яаман дээр энэ зураг төсөл батлагдаад, одоо ингээд магадлан Барилгын хөгжлийн төвөөр ингээд хянагдаад ингээд явж байгаа. Тэгээд жишиг зураг дотроо орчин үеийн таны хэлсэнчлэн дулааны алдагдалтай, ногоон хэв маягийн энэ жишгүүдийг нэвтрүүлээд шинэчилсэн 26 оны шинэ барилгууд дээр энэ шинэ жишиг зургаараа явахаар төлөвлөгдөөд ажиллаж байгаа.

Ч.Ундрам: Энэ дээр нэмж асуухад Батжаргал дарга энэ 108 сургууль, 95 цэцэрлэг гээд тэгж байгаа шүү дээ. Гэтэл бид нөгөө бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль гэдэг концепцоор урт хугацаандаа явъя гэж байгаа шүү дээ. Тийм учраас эхний ээлжид дандаа бага сургуулиуд бариад, тэр чинь угаасаа бага төсвөөр төсөв шаардагдана. Тэгээд одоо байгаа сургуулиудынхаа бага ангийн хүүхдүүдийг энэ бага сургууль руугаа оруулаад ингээд явна гэсэн тийм бодлого явж байгаа гэж би ойлгоод байгаа юм. Энэ дээр яг тийм бага юм уу, ахлах юм уу гэдэг тодотгол байхгүй байна. Энэ дээр та хариул даа 6 номер.

Х.Батжаргал: Байнгын хорооны даргын тодруулгад хариулъя. Тийм ээ энэ 26 оны жилийн төлөвлөгөө дээр яг тодорхойлон нарийвчилж бол заагаагүй. Бодлогынхоо хувьд яг ийм хэрэгцээ шаардлага байна гэдгийг гаргаж ирсэн. Одоо харин бид Байнгын хорооны даргын ахалсан ажлын хэсэг чанарын асуудлыг хариуцаж байгаа, манай хүртээмж болон хөрөнгө оруулалтын асуудлаар Галбадрах гишүүн ажлын хэсэг ахлаад ажиллаж байгаа. Яг энэ хүрээнд нарийвчилсан тооцооллууд хийгдээд байршил, мөн түүнчлэн чанартайгаа уялдуулаад бага сургууль нь хаана байх юм, ахлах сургууль нь хаана байх юм, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу төрөлжсөн ахлахуудыг яг хаана, хаана, ямар түвшинд байгуулах вэ гэдгийг ажлын хэсэг дээр ярилцаад, төсвийн боловсруулалтын түвшинд бид нарийвчилсан тооцоотойгоор оруулаад явах боломжтой гэдэг үүднээсээ урьдчилаад бодлогодоо үндсэн томоо хэрэгцээ шаардлагаа тусгаад 108, 95 гэдэг тоо гаргаж ирсний 45, 45-ыг энэ жилийн төлөвлөгөөндөө тусгаад явж байгаа гэж бодож байгаа. Тэгээд дээр нь нэмээд сая.../минут дуусав/

Ч.Ундрам: Энэ төсөвтэй холбоотой түрүүн Хосбаяр гишүүн хэлж байна л даа. Энэ дээр Сангийн яам юм уу, Эдийн засгийн хөгжлийн яам хариулах уу? Жишээлбэл нэг сургуулийн төсвийг 3 жилд хувааж тавиад байгаа байхгүй юу. Тэгээд сүүлийн үеийн технологиор нэг жилд нэг сургуулийг компаниуд барьчихаад байдаг, улс барих болохоороо 3 жил. Тэгээд л жилээс жилд нөгөө өртөг нь өсөөд л, дахиад зураг төсвөө шинэчлээд л магадлангаар оруулаад ингээд л заваараад явдаг асуудал газар авч байна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого Сангийн яамнаас барьж байгаа вэ? Ганбат Сангийн яамны ТНБД, 4 номер.

Ж.Ганбат: Бид төсвийн боломжтой уялдуулаад төслүүдээ тусгаж байгаа. Яах вэ бид ер нь сүүлийн жилүүдэд сургууль, цэцэрлэгийн хүртээмж дээр ЗГ-аас онцгой анхаарч байгаа. Бид энэ хүрээндээ газартай зураг төсөв нь бэлэн ийм сургууль, цэцэрлэгүүдийн барилгыг ер нь нэг жил төсвийг нь тавьж дуусах ийм бодлого тавьж байгаа. Яах вэ зарим тохиолдолд 1-ээс 2 жилийн хугацаанд дуусах ийм байдлаар явж байгаа. Заавал бид 3 жил хувааж барина гэсэн юм бол байхгүй байгаа. Ирэх жил бид боловсролын жил гэж зарласантай холбогдуулан ирэх оны төсөв дээр ЗГ-аас энэ сургууль, сургуулийн энэ хүртээмж дээр онцгой анхаарч байгаа. Энэ дээр бид ирэх оны төсвийн төслийг боловсруулахдаа энэ дээр онцгой анхаарч ингэж ажиллахаар Боловсролын яамтай хамтарч ажиллаад явж байгаа.

Ч.Ундрам: Аялал жуулчлалтай холбоотой асуултад Номин сайд хариулъя.

Ч.Номин: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Манай аялал жуулчлалын салбарт ер нь тогтвортой дараагийн 5 жилийн хугацаанд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байгаа. Бид саяхан олон улсын томоохон байгууллагатай хамтраад өөрсдийнхөө 2030 он хүртэлх стратегия баталсан. Энэ дээр 2 сая жуулчин хүлээж авна гэж үзэж байгаа. Ингэхийн тулд бид ер нь төр, хувийн хэвшил аль, аль талаасаа нийлээд 4 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалт буюу 11 их наядын хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа. Тийм ч учраас бид энэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс бага хүүтэй, урт хугацаатай зээлийг гаргаж байгаа. Өнөөдөр ЗГ-аар тогтоол батлагдсан. Энэ жилдээ 200 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр гаргах боломжтой. Энийгээ хийхдээ арилжааны банкны үндсэн суурь зарчим дээр суурилан арилжааны банктай хамтарч гаргахаар төлөвлөж байгаа.

Тэгээд Хосбаяр гишүүнтэй санал нэг байгаа зүйл юу байна вэ гэхээр энэ ингээд нэг удаа хийгдээд ч юм уу, бага хэмжээтэй хийгдвэл энэ аман ч үгүй, хамар ч үгүй болоод дуусах байх. Тэгэхээр бид 4 улирлын аялал жуулчлалыг дэмжсэн буюу өвлийн улирал үйл ажиллагаа явах боломжтой болгож өөрийнхөө аялал жуулчлалын байгууллагуудыг үйл ажиллагааг тэлсэн, хөрөнгө оруулалт оруулсан, үүнээс гадна олон улсын стандартад нийцсэн байдлаар өөрсдийн байгууллагуудаа сайжруулсан тохиолдолд энэхүү санхүүжилтийг өгөхөөр 13-аас 14 төрлийн бүтээгдэхүүн болгож гаргахаар бэлтгэл хангагдаад байж байгаа. Тэгээд энийг дараагийн 5 жилийн хугацаанд тогтвортой явуулж байж энэ салбарт хөрөнгө оруулалт бодитоор орж, тэгээд олон улсын стандартад нийцсэн энэ дэд бүтцүүд бий болоод, 2030 он гэхэд тэр бид нарын тавиад, зорилт тавиад байгаа 2 сая жуулчныг хүлээж авах боломж үүснэ гэж үзэж байгаа.

Ч.Ундрам: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Тэр нөгөө төр, хувийн хэвшлийн түншлэлийг хариулсангүй. Тэгээд аялал жуулчлалын салбарын саяын тэр зээлийг тэр хувийн хэвшлийнхэн, аялал жуулчлалын холбооныхон ирж уулзсан л даа. Надад мэдээлэл өгсөн. Тэгээд тэр банкнууд чинь 1 тэрбумаас дээш зээл өгөхгүй гээд, тэгээд 1 тэрбумаар чинь л харин тэр нэг хэдэн жуулчны бааз 1 тэрбум төгрөгийн зээл аваад л, төрийн хөнгөлөлттэй зээл аваад л, тэрүүгээр нэг дорвитой юм хийж чадахгүй л дээ. Тэгэхээр л харин яг саяын сайдын хэлсэн шиг нэг төслөө шалгаруулаад, энэ бодлогоо өөрчлөөд нэг жоохон тийм яг дорвитой, яг хэрэгтэй хөрөнгө оруулалтууд хиймээр байна 1 дүгээрт.

2 дугаарт аялал жуулчлалын салбарт жишээлбэл аялал жуулчлалын энэ бүтээн байгуулалтууд чинь том, том үл хөдлөхүүд л байгаа. Тэгэхэд сая тэр ковидын үеэр хүртэл л үл хөдлөхийн татвараас жишээлбэл чөлөөлчихөд л уг нь тэр салбарыг дэмжих байтал үл хөдлөхийн татвараас хүртэл чөлөөлөөгүй. Ингээд л дэмжлэг бол тэр салбарт дутдаг л юм байна лээ л дээ.

Ч.Ундрам: Төр, хувийн хэвшлийн түншлэл дээр Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү, 3 номер микрофон.

И.Батхүү: Хосбаяр гишүүний асуултад нэмэлтээр мэдээлэл хүргүүлье. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг нэмэлт, өөрчлөлт оруулахаар Эдийн засаг, хөгжлийн яам төслийг нь боловсруулаад ажиллаж байгаа. Хуулийн өөрчлөлтийн гол агуулга нь гэвэл өмнөх хууль дээр байсан дэс дараалсан шат дарааллуудыг зэрэгцүүлж явуулах боломжоор хангаж байгаа. Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, ТЭЗҮ, нарийвчилсан судалгаа, урьдчилсан судалгаа гээд олон шат дараалалтай баримт бичгүүдийг агуулгын хувьд хянаад, давхцал, давхардлуудыг нь арилгаад нэг, нэг байхаар зохицуулж байгаа. Мөн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төслүүд дээр аль болох нарийн шинжилгээтэй баримт материалыг нь шаарддаг. Төрийн үйлчилгээг хүргүүлэх чиглэлийн төслүүд дээр ТЭЗҮ, техник, эдийн засгийн үндсэн судалгаа шаардахгүй байхаар өөрчлөлтүүд агуулгын хувьд орж байгаа. Яг боловсролын байгууллага сургууль, цэцэрлэгийн хувьд төрөөс аль эрсдэлийг нь даах вэ, хувийн хэвшил аль эрсдэлийг нь даах вэ гэдэг дээр эрсдэлийн хуваарилалтаа зөв тодорхойлж чадвал энийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой. Жишээлбэл төрөөс хөрөнгө оруулалт хийсэн төслүүдийг менежментийн хувьчлалаар.../минут дуусав/

Ч.Ундрам: 3 номер гүйцээгээд хариулъя.

И.Батхүү: Сургууль, цэцэрлэгийн байгууллагууд дээр жишээлбэл төрөөс үндсэн хөрөнгө оруулалтыг нь даагаад, цаашдаа үйл ажиллагааны зардлыг нь урт хугацаанд тодорхой хэмжээнд барих хэмжээнд шалгуур үзүүлэлтүүдийг хувийн хэвшилтэй тохироод, менежментийн хувьчлал маягаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагаагаар явуулж болно. Олон улсын жишигтэй бас энэ боловсролын салбарын төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлсэн сайн туршлагууд байдаг.

Ч.Ундрам: Номин сайд тодруулаад хариулаарай.

Ч.Номин: Хосбаяр гишүүний асуултад тодруулж хэлье. Түрүүний таны хэлж байгаа Аялал жуулчлалын мэргэжлийн холбооныхонтой уулзсан асуудал энэ өмнөх удаа гарсан зээлийн бүтээгдэхүүн дээр байсан болов уу гэж бодож байна. Тухайн үед хэрэгцээ шаардлагаа бүрэн тодорхойлоогүй, улсын стратеги гараагүй байсан учраас гарсан нөхцөл байдал учир дутагдалтай байсан тал байна лээ. Энэ удаад бид хамгийн гол зүйл нь юу байсан бэ гэхээр арилжааныхаа банкнуудтай урьдчилж тохиролцоод, ямар нэгэн лимитгүйгээр тухайн байгууллагын чадамж дээр суурилсан зээлийг гаргах энэ боломжийг бий болгож байгаа. Энийг хийхдээ бид гол чиглүүлж байгаа зүйл нь юу вэ гэхээр байрших үйлчилгээ буюу зочид буудал, кампуудыг сайжруулах, тээврийн хэрэгсэл гээд олон чиглэл рүү хийж байгаа, түрүүний хэлсэн арваад бүтээгдэхүүн дээр. Дээрээс нь таны хэлээд байгаа 1 тэрбум бол эргэлтийн хөрөнгийн түвшнийх болов уу гэж танд мэдээлэл өгсөн юм болов уу гэж бодож байна. Тэгэхээр танд тодруулаад хэлэхэд банкнуудтайгаа хамтарч ажиллаж байгаа, ямар нэгэн лимитгүйгээр томоохон хөрөнгө оруулалт оруулах боломжтойгоор хийж эхлүүлж байгаа бөгөөд урт хугацаандаа энэ.../минут дуусав/

Ч.Ундрам: Номин сайд гүйцээгээд хариулчих.

Ч.Номин: Тэгээд урт хугацаандаа түрүүн хэлсэн харин энэ 4-өөс 5 жил тогтвортой явах дээр гишүүнийг хамтарч ажиллаасай гэж хүсэж байна. Ингэж байж түрүүн бид нарын хэлээд байгаа энэ чинь аялал жуулчлалын салбарт оруулдаг хөрөнгө оруулалтууд тийм бага дүнтэй биш байдаг хувийн хэвшлээс. Тэгэхээр урт хугацаагаар төлөвлөж, өндөр дүнтэй хөрөнгө оруулалтыг оруулж явснаар энэ салбарт таны хэлээд байгаа энэ боломжуудыг бий болно гэж үзэж байгаа.

Ч.Ундрам: Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Төр, хувийн хэвшлийн түншлэлээр сургууль, цэцэрлэг барих юмаа л нэг онцгой сайн анхаарч боловсруулмаар л байгаа юм. Хувийн хэвшилд боломж байгаа юм, зөндөө хүмүүс уулзаж байна. Сая Ундрам дарга ч хэлж байна. Хувийн компаниуд хороолол дотроо сургууль барихаараа жилийн дотор барьчаад байна шүү дээ. Тэгээд улс болохоор ингээд удаад байдаг. Тэгэхээр барилга чинь ерөөсөө л тэр хөрөнгө санхүүжилт нь шийдэгдээд, мөнгө нь л байвал хурдан хийчхэж болдог зүйл л дээ. Тэгээд би яагаад энэ сургууль, цэцэрлэгийн барилгыг яриад байна вэ гэхээр энэнээс чинь болоод л нэлээн их проблемууд үүсээд байгаа шүү дээ. Нийгмийн бухимдал, сургууль, цэцэрлэг хүрэлцэхгүй байна, хүүхдүүд 3 ээлжээр хичээллэж байна, сургуулийн орчин муу байна гээд.

Тэгэхээр энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ юман дээр нэг бүр яг энэ сургууль, цэцэрлэгийг нэг онцгой анхаараад, нэг арай өөр зоригтой алхам хийж болохгүй юу? Тэгэхгүй тэгээд л урьд нь ярьдаг юмаа яриад л ингээд л, тэгээд л хувийн хэвшил нь нэг хийгээд л явна. Тэгээд жил, 2 жилд хуваагаад тавина гээд ингээд л явахаар тэгээд нэг дорвитой өөрчлөлт гарахгүй байх гэж хараад байна л даа. Тэгэхээр хувийн, төр, хувийн хэвшлийн.../минут дуусав/

Ч.Ундрам: Санал гэж ойлгох уу? Батхүү дарга 3 номерын микрофон.

И.Батхүү: Гишүүний саналыг хүлээж авлаа. Боловсролын яамтайгаа хамтраад бид энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн эрх зүйн орчинд энэ үүсээд байгаа асуудлуудыг сургуулийн хүртээмжийг сайжруулах асуудал дээр анхаарч ажиллая.

Ч.Ундрам: Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: 26 оны төлөвлөгөө дээр хүн төвтэй хөгжлийн үзэл санаа гээд тэгээд боловсрол нэг талаас, нөгөө талаасаа соёл гээд. Тэгээд бид ер нь ямар иргэнийг энэ ирээдүйд бэлдэх гэж байгаа юм бэ гэдэг тал дээрээ дүгнэлт хийх цаг болсон юм шиг санагдаад байгаа юм. Монголынхоо түүх соёлыг мэдэхгүй, гаднын соёлд хэт автсан. Үндсэндээ Солонгосын Кпоп, сошиал медиа гэдэг дээрээ том, жижиггүй ороод, бүгдээрээ улс төр яриад суучихдаг нэг ийм л нэг ийм ард түмэн болж болох гээд байна л даа. Тийм учраас бид энэ Монгол өөрөө асар их түүхтэй, соёлтой ийм улс. Энийг тээж авч явах, энийг боловсролын хөтөлбөрт түлхүү оруулах, тэр дугуйлан, секцийг хичээллүүлэх энэ тал дээр онцгой анхаарах хэрэгтэй байгаа юм. Ерөнхий боловсролын сургуулиудын багш нар тодорхой хэмжээний багахан нэг төлбөр аваад дугуйлан секц хичээллүүлэх гэхээр тэрийг нь хориглочих юм. Тэгээд нууцаар бараг хийдэг. Тэгээд энэ чинь яг ингээд эрүүл үзэгдэл мөн үү, биш үү?

Бид нэг талдаа, зарим талдаа хэт их тийм юутай. Би тэр нөгөө соёлын ваучер энэ тэр гээд яриад байсан зөв ойлгосон бол уг нь маш их зөв асуудал байгаа. Монголынхоо түүхийг өв тээж байгаа энэ бид авч үлдэх, энийгээ би ирэх жилүүдэд тодорхой хэмжээгээр ахиж оруулж ирэх үү? Бид яах вэ тэр нийгмийн сошиал медиа гэдэг юм уу, янз янзын зүйлээс ингээд хэдэн үзвэрийн билет тараах гэж байна гэдэг байдлаар ойлгоод ингээд явчихсан. Тэгэхээр Монгол эрэгтэй хүүхэд гэхэд морин хуураа тоглож сурдаг эр хүн болмоор байна. Цагаан сараар нэг хуураа хөглөчихдөг том, жижиггүй. Тэгэхээр ийм өв соёлуудыг тээх талаар энэ төсөв, төлөвлөгөөнд чинь юм туссан уу?

2 дугаарт тэр сургууль дээр. Би сая Хөвсгөлийн хамгийн хойд талын сум дээр очсон л доо. Монгол Улсын хамгийн хойд талын сум хиллэдэг, Цагааннуур суман дээр сургууль барих гэсэн 9 удаа тендер зарлаад ороогүй. Яагаад ороогүй гэхээр тийшээ барилга барихад ойролцоогоор 10 цаг явж хүрдэг шороон замаар, маш хүнд нөхцөлтэй. Тэгээд энийг Сангийн яам эд нар, Сангийн яам эд нар энэ төсөв, төлөвлөгөөг нь яг ингээд шинэчлээд хийчхэж болоогүй юм уу? Энэ замын юуг ер нь яаж тооцдог юм бэ? Яг аймгийн төвийн хажууд 60км-ийн наана байгаа нэг сургууль барих нэг өөр, 10 цаг машинаар явдаг 200, 300км туулж очиж зам барилга барих нэг өөр л дөө. Тэгээд энэ төсөв, төлөвлөгөө чинь ер нь яаж явдаг юм бэ гэдэг тал дээр нэг хармаар байна, асуумаар байна.

Дараа нь тодорхой санал өгсөн юм энэ бид Боловсролын зээлийн сан энэ багш нараа ерөөсөө олигтой гадаад, дотоодод сургаагүй байна. Сургуулийн өмнөх цэцэрлэгийн багш сурсан тийм юу байна уу? Байхгүй. Ерөнхий боловсролын сургуулийн багш гадаадад сурсан уу? Байхгүй. Их дээд сургуулиудын багш хүмүүсийг гадаадад бодлогоор зээл өгөөд сургасан уу, байхгүй. Тэгээд хамгийн сурах ёстой, эргээд үр өгөөж нь хэд дахин үржигдэж ирэх хүмүүсээ хаячихсан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 26 онд тэр Боловсролын зээлийн тэтгэлгийн сангийн багагүй хувийг энэ боловсролын салбарт нь зарцуул. Сургуулийн өмнө боловсрол гэхээрээ үндсэндээ нэг хүүхдийг нэг хоол өгөөд л нэг харсан болоод хаядаг гэж ерөөсөө үзэж болохгүй. Бараг 7 нас, хүүхэд 7 настайдаа ямар хүн болох вэ гэдэг нь бараг төлөвших үе байхгүй юу. Бид энийг хаячихдаг юм байна. Тийм учраас энэ тал дээр цоо шинээр ингээд авч үзмээр байна. Багш нарыгаа өөрсдөө боловсролын салбарын өөрийг нь боловсруулах хэрэгтэй болчихоод байна. Энд нь хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй байж байна.

Дээрээс нь энэ орон сууц гээд нийтлэг утгаар нь тавьчихаад байгаа. Яг энэ хороолол хорооллоор нь тэр 20 минутын хот байна уу, багш нар, эмч нар, сургуулийн багш, ажилчдыг нийлүүлээд ийм хотхоны төлөвлөлт хийж болохгүй байна уу? Боловсролын яам энэ дээр нь оролцоод, сургуулиудаа оролцуулаад, зээл хуулийг нь шийдээд. Тэгвэл тэр багш нар чинь заавал замын түгжрэл үүсгэж гэж ажил руугаа явахгүй шүү дээ. Тийм учраас энэ тал дээр нийгмийн асуудал шийдэх зорилго дээр юу байна вэ? 1 минутаа нэмээд авчихъя даргаа.

Ч.Ундрам: Эрдэнэбат гишүүнд 1 минут нэмж өгье.

С.Эрдэнэбат: Соёлын яамнаас, спортын яамнаас нэг зүйлийг асууя. Энэ 10 жилийн хүүхдүүд янз бүрийн спортын тэмцээн наадам их болох юм, тэгээд зардал ерөөсөө байхгүй. Энэ хэдэн Их Хурлын гишүүдээс маш их гуйх юм хөөрхий. Харахаар өрөвдөөд тэгээд хаанаасаа гаргаж өгдөг байдалтай. Спортын холбоод чинь зарим нь яг үнэндээ дампуурчихсан, нэг хүний өмч болчихсон юм байна лээ шүү дээ. Би тэр Тэшүүрийн холбоо гээд очсон. Манай нутгийн хэдэн хүүхдүүд ирсэн. Тэнд бараг 14, сар нэг гэр түрээслээд хөөрхий аав, ээж нь хараад суучихсан, боорцог хайрчихсан, тэмцээнээ хүлээгээд сууж байгаа юм. Нөгөө тэшүүрийнх нь холбооны өмчийн газрыг нь тойруулаад house барьчихсан Хандгайтад. Тийм учраас Спортын сайд энэ массын спорт, тэр тусмаа өвлийн спортыг дэмжихэд тодорхой төсөв хөрөнгө тавьж өгөөд, энэ өвлийн спортоор ялангуяа манай Монгол Улс энэ Азиуд чинь дэлхийд олимпын медаль авах хамгийн найдвар өндөртэй юм байна лээ шүү дээ. Тэр Солонгосоос нь байна уу, хаанаас байна уу багш нарыг нь авчирч ирээд, жоохон дэмжээд өгөх ийм хэрэг байгаа юм байна лээ. Тэгэхээр Хөвсгөл нууран дээр гэдэг юм уу, энэ дараа нь тодруулга авах уу?

Ч.Ундрам: Саяын асуудалтай холбоотой би нэмээд хэлчихмээр байна. Өнөөдөр 21 дүгээр зуунд хүүхдүүд 54 ширхэг зуух өрөө өрөөндөө тавиад галлаад хичээллээд сууж байгаа ийм сургууль байна. Сая ярьсан Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумд. Тэгээд төсөвт сургууль барина гээд мөнгө тавьчихсан. Гэтэл тийм хол газар, цэвдэгтэй газар очиж байшин барих сонирхолтой нэг ч компани байхгүй, тендер зарлаад л байдаг ордоггүй. Тэгэхээр цаашид энд Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамныхан байгаа дээр энэ 48 дугаар өргөргөөс хойшоогоо цэвдэгтэй бүс нутагт байшин барих зураг төсвийг нь арай өөр байдлаар тооцож тавимаар байгаа. Дээрээс нь зам байгаа юу, үгүй юу, зам, харилцаа. Тэгэхгүй бол

компаниуд ерөөсөө орохгүй байна. Тэгээд тэнд хүүхдүүд өнөөдрийг хүртэл тэгж өвөл маш хүйтэн модон байшин дотор гал галлаад, хүүхдийн аюулгүй байдалд хүртэл тэр чинь маш сөрөг нөлөөтэй ийм нөхцөл байдалд сурсаар байна шүү. Тэгэхээр ирэх жил боловсролын жил гэж ЗГ зарлачхаад, тэгээд нөгөө модон байшинтай, гал түлдэг зуухтай сургуультайгаа сууж байвал ёстой онигоо шүү яг үнэнийг хэлэхэд.

Тэгэхээр энэ дээр бүүр онцгой анхаараасай гэж хүсэж байна. Тэгээд эхлээд энэ нөгөө сургуулийн хөтөлбөр соёл, Монгол уламжлалтай холбоотой зүйлсээ зааж өгөхгүй бол болохгүй байна гээд ерөнхийдөө боловсролын асуудлыг нэлээн асуусан учраас 6 номер Батжаргал Төрийн нарийн хариулья.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулья. Ер нь хөтөлбөрийн ерөнхий болон ерөнхий боловсрол болон сургуулийн өмнөх боловсролын сурагчдын хөтөлбөрийн шинэчлэлийн ажлууд хийгдээд явж байгаа. Зүгээр үүний нэгээхэн хэсэг нь 2026 онд хэрэгжээд явна. Хөтөлбөрт хичээлээс гадуурх цагийг тусгайлан гаргаад, тэнд сургууль, секц дугуйлан явуулах ийм боломж бололцоог бүрдүүлээд ингээд шинэчилсэн хөтөлбөрт тухайлан зохион байгуулаад энэ түүх, соёлын хичээлийн хичээлээс гадуурх. Гэхдээ энэ өөрөө шууд нөгөө хүртээмжтэй холбоотой асуудал болоод явчихдаг. Ер нь бүгд бүх сургуулиуд нэг ээлжид орж байж л дараад нь хичээлээс гадуурх энэ бусад секц, дугуйлан, бусад цаг заваа зарцуулах энэ боломж бүрдэнэ. Тэрний төлөө л энэ хүртээмжийг нэмэгдүүлэхээр боловсролын жилийн хүрээнд энэ олон сургууль, цэцэрлэгийг нэмэгдүүлэх ажил явж байгаа. Гэхдээ энэ хангалттай биш. Дараа нь үе шаттайгаар 1 дүгээр ээлж рүүгээ, нэг ээлж рүүгээ орох ажлууд хийгдэх юм байгаа юм. Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд энэ ажлууд төлөвлөгдөөд явна гэдгийг мэдээлэл болгож хэлэх байна. Шинэчлэлийг хийх хөтөлбөр дунд ангиас яг энэ хэрэгжилт 27 оноос яг бүрэн нэвтрээд хэрэгжиж ажиллах болох юм.

Зээлийн сангийн зарцуулалтын тухайд сонгон шалгаруулалтын журам дөнгөж саяхан ингээд батлагдаад олон нийтэд хүрээд ингээд ажиллана. Багшийн мэргэжлийг тэргүүлэх мэргэжилд оруулаад, багш нарыг гадаадад Боловсролын зээлийн сангаар сургах энэ боломжийг бүрэн нээгээд өгчхөж байгаа юм. Зүгээр хараахан энэ шинэ тутам орж байгаа шинэ хуулийн эрх зүйн зохицуулалт учраас төгсөөд гараад ирсэн яг энэ журмаар зохицуулагдаад гараад ирсэн багш нар бол хараахан байхгүй ч гэсэн энэ боломж бүрэн нээгдээд явж байгаа гэж хэлэх байна.

Ч.Ундрам: Болчихсон уу? Хөтөлбөртэй холбоотойгоор юу билээ нөгөө Боловсролын хөгжлийн хүрээлэн дээр ажлын хэсэг, Боловсролын хүрээлэн дээр ажлын хэсэг байгуулагдчихсан. Тэгээд энэ хөтөлбөрийн агуулгаараа бид Монголын энэ уламжлал, соёл, түүх энийг оруулж өгч байгаа. 1, 2 дугаар ангийн ер нь бага ангийн хөтөлбөр боловсруулчихсан туршилт явчихсан байгаа шүү дээ. Одоо дунд ангийн хөтөлбөр явж байгаа. Тэгээд бид хичээлийн агуулгаараа хөдөлмөрийн хичээл гэхэд тэр юу гэдэг юм дээл оёх ч байдаг юм уу, биеийн тамирын хичээл гэхэд эрийн 3 наадмаа тэнд заагаад өгчихдөг ч юм уу ийм агуулга руу явж байгаа гэж ойлгож байгаа шүү. Зөв биз дээ Батжаргал дарга? Тэгээд энэ маань ингээд цаашаагаа хичээлийн агуулгадаа, тэгээд 1 ээлжид орсон сургуулиуд ирэх 9 сарын 1-нээс эхлээд үдээс өмнө танхимын хичээлүүд, үдээс хойш спорт, урлагийн дугуйлангууд ажиллаж эхэлнэ гэж ойлгож байгаа шүү дээ. Би яг тэгж ойлгоод, ярилцаад яваад байгаа гэдгээ өнөөдөр бүүр албан ёсоор хэлж байна шүү.

Түрүүн манай 2 Төрийн нарийн аягүй том мэдэгдэл камер дээр хэлчихлээ шүү. Манай Батхүү дарга, Ганбат дарга нар ер нь ирэх жил боловсролыг дэмжих жил учраас ахиухан сургуулиудаа барьчихна, төр, хувийн хэвшилтэйгээ хамтраад энэ боловсролын салбарт хөрөнгө оруулалтуудыг шийдэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ гээд сая яг хариуцлагатайгаар мэдэгдсэн байгаа шүү. Энэ протоколд үлдэнэ. Тэгээд энийг манай Боловсролын яамныхан, манай гишүүд аягүй сайн бичлэгийг нь тараана. Тэгээд дараа нь хариуцлага тооцно шүү гэж хэлмээр байна. Номин сайд асуултад хариулъя.

Ч.Номин: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Би тантай санал нэг байна. Бид Монголд ямар хүн бэлдэж, дэлхийн бусад улсын хүүхдүүдтэй яаж өрсөлдөх гээд байгаа гэдгээ тодорхойлох нь хамгийн чухал. Мэдээж боловсролын, албан боловсролын хүрээнд мэдээж хүмүүжил, үндсэн суурь боловсролыг олгодог. Хүнийг хүн болгодог зүйл бол яах аргагүй энэ соёл байдаг. Тэгээд энийг албан бус боловсролын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Тэрнээс гадна энэ гэр бүл бол соёлын анхдагч орчин гэж үздэг. Мэдээж тодорхой түвшинд академик чадваруудыг боловсролоор дамжаад авч байгаа. Гэхдээ сүүлийн үед дэлхийн хүмүүсийн чиг хандлага, дээрээс нь ирээдүйд бий болж байгаа энэ хүүхэд, залуучуудын байгаа нөхцөл байдал бол зөөлөн ур чадварууд байгаа. Энэ бол яах аргагүй соёл, өв соёлоо сурч мэдэх, дээрээс нь биеийн тамир, спортоор хичээллэх, дээрээс нь сэтгэн бодох чадвараа хөгжүүлэх.../минут дуусав/

Ч.Ундрам: Номин сайд гүйцээгээд хариулчих.

Ч.Номин: Энэ олон ур чадваруудыг хөгжүүлж байж бид ирээдүйд дэлхийд өрсөлдөх чадвартай, Монгол өв соёлоо мэддэг, дээрээс нь өөрийн гэсэн өөрөө өөртөө итгэлтэй иргэдийг бэлдэнэ. Энд хамгийн чухал зүйлүүд энэ албан боловсролоос гадуур хийж байгаа хичээлийн хөтөлбөрүүд байгаа. Энэ ч утгаараа бид энэ Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж гаргаж ирсэн. Энэ бол хуулийн заалттай. Энэ хуулийн заалттай соёл, спортын эрхийн бичгээ бид хэрэгжүүлээд аваад явна гэж бодож байгаа. Бид бүгд мэдэж байгаа, өөр зорилгоор улс төрийн хүрээнд энийг гуйвуулсан. Бид ирээдүйн хүүхдээ дэлхийд өрсөлдүүлнэ гэж бодож байгаа бол дэлхийд хэрэгжиж байгаа энэ хөтөлбөрүүдийг ялгаагүй Монголд хэрэгжүүлж авч явах ёстой гэдэг байр суурьтай байгаа.

Спортын салбар дээр асуулаа. Бид үнэн, энэ хүүхдүүдэд зориулсан манай соёл, спортын салбар хамгийн бага төсөвтэй байдаг. Энэ хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд бид тодорхой унааны мөнгө, дээрээс нь хоолны мөнгө, тодорхой зардлыг өгдөг. Энэ бол хүрдэггүй, бид нэмэгдүүлэх шаардлагатай байгаа. Энэ олон тэмцээн уралдаан хийж байж хүүхдүүд спортод дуртай болно, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ, дахиад дээрээс нь тэмцэх чадвар хүртэл нэмэгддэг. Тийм учраас цаашид энэ хүүхдүүдэд зориулсан тэмцээн уралдаан, спортын арга хэмжээнд зориулсан санхүүжилт шаардлагатай байгаа. Энийг улсаас тодорхой түвшинд санхүүжүүлээд явдаг байгаа. Энэ төсөвт суугаад явдаг.

Ч.Ундрам: Тэгээд гишүүддээ хандаж хэлэхэд ер нь манай Байнгын хорооны төсөв дотроо энэ соёл, спортын төсөв хамгийн бага, бүүр үнэхээр зарим нэг мега төслийн бүүр 10 хувьд ч хүрэхээргүй бага ийм төсөвтэй байгаа шүү. Тэгээд үнэхээр энэ хүний хөгжилдөө мөнгөө зориулъя гэвэл яг энэ хүүхдүүдийн боловсрол, соёл, спорт, бие бялдар гээд энэ зүйлүүд рүү бид хөрөнгө оруулахгүй бол ирээдүйд

Монгол өв соёлоо мэдэхгүй, дээрээс нь юу гэдэг юм бие бялдрын хөгжил муутай ийм хүүхдүүд төрөх хувь тавилан хүлээж байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Эрдэнэбат гишүүн нэмэлт тодруулга асууя.

С.Эрдэнэбат: Би нэг бас давхар ажил хэргийн түрүүн хэлэх гэсэн амжсангүй. Өвлийн спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор ядаж Хөвсгөл нууран дээр хүмүүс өвөл очихоор их хүйтэн байдаг юм дасгал хөдөлгөөн хийхэд. Тэгэхээр энэ манай Сүхбаатарын талбай дээр байдаг шиг ийм том хоол хийгээд байгаа том асар байна шүү дээ иймэрхүү зүйлийг ядаж хийж болохгүй байна уу? Ганбат дарга, Номин сайд 2 ярьж байгаад. Тэнд хүмүүс өвөл очдог. Одоо 1 сард хүүхдүүд амрахаараа хаачдаг вэ утаанаас гарахыг хүсдэг шүү дээ. Хойшоо аймгууд руу хөдөө гаръя гэхээр тэнд очоод хийх юм байхгүй. Тийм учраас нөгөө хүүхдийнх нь спорт нь ч байж байг, аялал жуулчлалынхан нь ирээд ч гулгаж байг нэг иймэрхүү байдлаар ингээд өвлийн аялал жуулчлал, спорт, хүүхдийн тэр хөгжлийн агаарт гарах гэдэг юм уу ийм цогц ийм 3 асуудлаар ядаж нэг энэ ирэх жилийн төсөв дээр өвөл гэдэг байдлаар нэг юм тавиад өгч болохгүй юу бүс бүсэд ядаж? Тэр голын юун дээр ч байна уу, юун дээр Хөвсгөл нуур, тэр баруун Увс нуур дээр ч байна уу. Тэгэхээр ийм байдлаар нэг юмыг оруулж өгөөч гэж хүсэлт байна гэдгээ хэлмээр байна.

Ч.Ундрам: Өвлийн аялал жуулчлалтай холбоотой төлөвлөгөө Номин сайд хариулъя.

Ч.Номин: Гишүүн ер нь бид өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ гээд 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ гэдэг хүрээнд эдгээр асуудлууд явагдаж байгаа. Аливаа зүйл бид тухайн газраа дэд бүтэц байхгүй бол эдгээр арга хэмжээнүүд маань аль, аль талдаа хэрэгжихэд тун хүндрэлтэй байгаа. Тийм учраас бид хамгийн түрүүнд тухайн байршлууд дээр хэлээд байгаа энэ дотоодын аялал жуулчлалын хүрээнд явж байгаа жуулчдад зориулсан дэд бүтцийг бий болгох, дээрээс нь байрших үйлчилгээнүүдийг бий болгох нь чухал гэж 1 дүгээрт харж байгаа.

2 дугаарт ер нь бүс нутаг болгон дээр аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож өвөл арга хэмжээнүүд тавигддаг, дахиад л төсөв мөнгөний учир дутагдалтайгаасаа болоод бага байдаг. Тэгэхээр бид Харбины, Харбин хоттой хамтраад өвлийн спорт болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр нэгдсэн ажил хийхээр бид хамтраад тохиролцоод, тэдний туршлагаас судлаад энэ ажлыг багцаар нь харж байгаа. Тэгээд багцаар нь харахдаа бид дотоодын өвлийн аялал жуулчлал, дээрээс нь өвлийн спортыг хөгжүүлэх чиглэл.../минут дуусав/

Ч.Ундрам: Энэ асуултын нэрсийн жагсаалтад Баярмаа гишүүний нэрийг оруулаад өгөөрэй. Тэгээд Галбадрах гишүүн асуулт асууя.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе та бүхэндээ. Би дараа нь мэдээлэл өгөх учраас дараа нь больё гэсэн та хэд маань ингээд гараад явчих хүмүүс юм байна. Тийм учраас би байгаа дээр нь мэдээлэл өгчихье гэж бодлоо ажил хэсгийнхэндээ зориулаад. Яах аргагүй л хүн болгон ярьж байна. Ирэх жилийг 26 оныг Боловсролыг дэмжих жил болгосон. Дотроо хүртээмжийн асуудал, чанарын асуудлыг ярья гэсэн. Тэгээд хүртээмж, чанар дээрээ нэг, нэг дэд хэсгүүд гараад ингээд явж байгаа. Тэгээд би олзуурхаад өөрөө хүртээмжийн дэд ажлын хэсгийн яаман дээр, ЗГ дээр хариуцаад явж байгаагийн хувьд Сангийн яам, Боловсролын

яам хоорондоо яг тоон дээрээ тохироод, юугаа ингээд юу гэдэг юм хамтраад явж байгаа нь их таатай байгаа.

Тэгээд түрүүн Ундрам даргын хэлсэнчлэн бага сургуулийн концепц ч гэдэг юм уу, Улаанбаатар хотод ялангуяа бид тэр чиглэл рүү явахын тулд яах вэ гэдэг асуудлуудыг сангийн, ЗГ-ын Ерөнхий сайдын Ажлын албаныхантай яриад, Нийслэлийнхэнтэй яриад тэр чиглэл рүүгээ орох гэж байгаа. Тэгээд ер нь эрэмбээ тогтоож явах ёстой, цогцоор нь харах ёстой гэдэг юмыг хэлмээр байна. Соёлын яам ч гэсэн Боловсролын яамтай угаасаа нэг байсан үе байгаа. Тийм учраас ерөөсөө салгаж болохгүй, энэ бүх зүйлийгээ хамтдаа яваарай, явах ёстой юм байна. Тэгээд бид эрэмбэ тогтоогоод үзэхээр ерөөсөө боловсролын салбарт шинэчлэл хийх эрэмбэ маань 1 дүгээрт л энэ хүртээмж, тэгээд багшийн асуудал, яалт ч үгүй энэ 2 асуудлыг л өнөөдөр тулгамдчихаад байгаа. Тэгэхээр хэдүүлээ 26 ондоо нэлээн цогц бодлоготой, тэгээд нэлээн зоримог хийгээд, энэ дээрээ шинэчлэл хийе гээд байна. Тэгээд 108 сургууль, 95 цэцэрлэгийн асуудал яригдаад байгаа. Энийгээ 3 жилдээ 26, 27, 28 оны төсөвт хуваагаад тавьчихна гэж ойлгож байгаа. Эхнээсээ тавьсан байгаа.

Энэ бол ерөөсөө сургалтын чанарын асуудлыг л ярьж, тэнд байж байгаа орон нутагт сургууль байхгүй учраас эсвэл сургууль нь насжилт нь ихэссэн учраас гэж барьж байгаа юм биш. Энэ бол ачааллыг багасгаж, сургалтын чанарыг ярих тал руугаа л орж хийж байгаа асуудал шүү. Тэгээд өнөөдөр хэд хэдэн гишүүн маань Бум-Очир гишүүн маань ч хэллээ, Хосбаяр гишүүн ч хэллээ. Тэгээд энэ барилга юуны тал дээр, багшийн хомсдолыг л яах вэ гэдэг асуудал дээр л дахиад би асуучихмаар л байна л даа. Ирэх жил ингээд 40 хэдэн сургууль шинээр барилаа. Одоо ингээд ороход юу дутах вэ гэвэл ерөөсөө л одоо угаасаа 4200 багш дутагдалтай гэж гарч байгаа бол ахиад багш бүр дутна. Тэгээд зах зээл дээр 30 мянга гаруй багш мэргэжилтэй мэргэжлээрээ ажиллаагүй хүмүүс байна. Энийг татах талаар та нар ямар бодлого бодож байна гэдгийг 1 дүгээрт асууя.

Дараа нь ажлаас маш их гарч байна, хүмүүс ажлаас гардаг хурд жилд бүр 10 хувь энэ тэр, ажилд орчхоод тэгээд 10 хувь нь дараагийн жилд нь гараад явчхаж байгаа ийм асуудал байгаад байна. Энэ бол тэр цалинтай холбоотой. Дөнгөж залуу багш нар 1 сая 490 мянган төгрөгөөс эхэлж байгаа энийг 2 сая болгочих энэ боломж яг багш дээр тусгайлан үзэх тал дээр Сангийн яам тийм бодлого байна уу? Тэгээд багш мэргэжлээрээ ажиллах хувь төгсөж гарч байгаа хүмүүс маш бага байна. 38 хувь дундаж байгаа. Өнгөрсөн жилийн дунджийг харахаар ердөө 15-хан хувь нь буюу 310 мянган, 310 хүн л багш болсон, 2900-гаад хүн төгсөөд байдаг. Тэгэхээр энэ хувийг МУБИС дээр багшаар бэлдэж байгаа, тэгээд тэтгэлэг энэ тэр хөнгөлөгдөж байгаа ийм нөхцөлд сурч байгаа хүмүүс дээр энэ ямар хариуцлага тооцож, яаж явах вэ? Төгсөгчдөө багш мэргэжлээр нь ажиллуулах дээр.

Тэгээд хамгийн эцэст нь энэ ипотекийн зээлийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас ч юм уу бодлого гаргаад, багш дээр ипотекийн зээлийг очер дугааргүй болгох тал дээр ямар бодлогууд юу байна тэрийг асууя? Баярлалаа.

Ч.Ундрам: Батжаргал дарга 6 номер хариулъя.

Х.Батжаргал: Яах аргагүй боловсролын чанар дээр багшийн асуудал хамгийн чухал асуудал болоод, 26 оны жилийн төлөвлөгөөнд багшийн 3 тулгуурт бодлого гэж ЗГ-аас баталсан бодлого байгаа. Тэр хүрээндээ багшийн тогтвортой

ажиллах нөхцөл, төгсөөд гарсан багш нарыг яг мэргэжлээр нь ажиллуулах тэр чиглэл, нийгмийн баталгааг нь хангах чиглэлээр баримтлах гэх мэтчилэн тодорхой заалтууд туссан байдаг. Зүгээр энийг яг цэвэр, яг илүү нөгөө амь оруулах гэдэг утгаараа, илүү нөгөө хэрэгжилт тал руу нь мэдээж шууд урсгал зардалтай холбоотой болоод явчхаж байгаа. Тэгэхээр жилийн төлөвлөгөөнд боловсролын жилийн хүрээнд энэ багшийн 3 тулгуурт бодлогын хэрэгжилтийг хангах чиглэл ерөнхий агуулгаар ороод, төсвийн боловсруулалтын явцад урсгал зардал дээр илүү энэ хөшүүргүүдийг яаж ашиглах вэ, яаж нэмэгдүүлэх боломж бололцоо байгааг ажлын хэсэг дээр ярьж байгаад, Сангийн яамтайгаа зөвлөлдөж байгаад ингээд цаашаа явуулах ёстой. Яах аргагүй энэ урсгал зардал төсвийн асуудал болоод явчхаж байгаа.

Зүгээр хувилбарын хувьд мэдээж дэмжих жилийн хэмжээнд тусгайлсан арга хэмжээг 24 оноос авч хэрэгжүүлээд уг нь явж байгаа. Тухайлбал зах зээл дээр байгаа багш мэргэжилтэй боловч багшийн ажил хийхгүй байгаа иргэдийг ажилд эргүүлж авах чиглэлээр ажлуудыг зохион байгуулах ийм төлөвлөлтүүд байгаа. Мөн адилхан энэ санхүүгийн схем механизм энэ хөшүүргийн асуудлууд байгаа. Мөн түүнчлэн нөгөө тогтвортой ажиллах, ажлын байран дээрээ ажиллаад, төгсөж ажиллаад эхний 5 жилдээ бараг 50 хувь нь эргээд өөр ажил мэргэжлээр ажиллачихдаг гэсэн судалгаа байдаг. Тэгэхээр зэрэг бид энэ 5 жилд, цаашлаад 3 жил тутам ингээд 6 сарынх нь цалинг тооцож олгодог энэ механизмыг илүү боловсронгуй болгох, эхний 5 жил дээрээ тогтвортой ажиллачихвал цаашлаад багш маань зэргийн нэмэгдэл урамшуулал гээд бусад асуудлууд маань нийгмийн асуудлууд маань нэлээн шийдэгдээд явах ийм нөхцөл бүрдчихдэг учраас эхний 5 жил дээр тогтвортой ажиллуулах энэ ажил бол чухлаар тавигдаж байгаатай холбогдуулаад төлөвлөлтдөө оруулаад явж байгаа.

Ч.Ундрам: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, 4 номерын микрофон дээр хариулт өгнө.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Яг бид нарын хэлэлцэж байгаа энэ жилийн улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулаад нэг бодлогын баримт бичиг нөгөө талд хэлэлцэж байгаа нь төсвийн хүрээний мэдэгдэл байгаа. Тэгэхлээр бодлогын аливаа шийдвэр маань өөрөө эх үүсвэртэйгээ уягдах ёстой, төсөвтэйгээ уягдах ёстой. Тэгэхлээр төсвийн хүрээний мэдэгдэл бол яг энэ жилийнх нь түвшинд байж байгаа. Намар бол төсөв бид жилийн төсвийг хийхдээ Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна гэдэг үндсэн заалттай, зорилготой. Тэгэхлээр намар төсөв дээр энд хөгжлийн төлөвлөгөө дээр орсон зүйлүүдийг төсвийн хүрээний мэдэгдлийн тэр хүрээн дотроо оруулж бид багтааж явуулна гэсэн үг.

Товчхондоо хэлбэл энэ жилийн төсөв, ирэх жилийн төсөв 2 ижилхэн байна гэдэг маань хэрэв бид цалин хөлсийг, тэтгэвэр тэтгэмжийг ирэх жил нэмэгдүүлье гэвэл энэ нь 1-ээс 1,5 их наяд төгрөгийн асуудал гарна. Энэ хэмжээгээр зарлагыг бид хэмнэх хэрэгтэй болно. Тэгээд үлдсэн.../минут дуусав/

Ч.Ундрам: Санжаадорж дарга гүйцээгээд хариулъя.

М.Санжаадорж: Мөн түүнчлэн жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр орон тоог 9 хувиар бууруулах, урсгал зардлыг 24 хувьд барих гээд тодорхой заалтууд

байгаа. Энийг бид хэрэгжүүлэх үүрэг авна. Тэгэхлээр нэг л сонголт үлдэнэ. Энэ юу вэ гэхлээр бүтээмж гэдэг зүйл рүүгээ л явна гэсэн үг. Тэгэхлээр бид энэ төсвийн мөнгийг яавал үр ашигтай, хамгийн бүтээмж өндөртэй байхаар хуваарилах вэ гэдэг энэ арга руугаа, энэ зүйл рүү л хамгийн тэргүүн ээлжид эрэмбэлж орно. Тэгэхлээр салбар яам бол салбарын яамнууд өөрсдийнх нь төсөв дотроо тэр хязгаартаа багтаагаад ямар байдлаар хамгийн үр дүнтэй байдлаар энэ төсвөө эрэмбэлж зарцуулах вэ гэдэг дээр санал нь намар төсөв рүү орж ирэхлээр бид түүн дээр нь ажиллаад, аль болох тэр саналуудыг бүгдийг нь төсвийн хүрээндээ багтаагаад нэгтгээд оруулж ирнэ гэсэн ийм байдалтай байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Энэ жилийг боловсролын жил болгож зарласан байгаа. Тэгээд өмнө хууль батлагдаад тэр хуулийнхаа дагуу Засгийн газрын мөрийн хөтөлбөр 2024-өөс 28 оны хооронд дараах заалтууд орсон байгаа юм. Энэ нөгөө 3 дугаар ангиас англи хэл заах, нөгөө роботик хиймэл дагуул, кодчиллын энэ чадварыг эзэмшүүлэх энэ сургалт нь хэзээнээс нэвтэрч эхлэх юм бол гэдэг ийм асуулт байна? Яагаад гэвэл энэ нөгөө мөрийн хөтөлбөрт тусчихсан байгаад байгаа.

Дээрээс нь энэ өндөр технологи, байгаль орчин, сансар судлалын мэдлэг мэдээллээр баяжуулан сургалтын агуулга, хөтөлбөрөө шинэчилнэ гэсэн ийм заалтууд ороод яваад байгаа. Гэхдээ харамсалтай нь яг энэ 2 заалтыг энэ 26 оны төлөвлөгөөнөөс олж харсангүй. Тэгэхээр хамгийн чухал, бид чинь энэ дэлхийн дэг журам бүхэлдээ өөрчлөгдөж байна, шал өөр ийм мэргэжил шаардлагатай болж байгаа энэ үед энэ заалтууд ингээд хэрэгжээд, бэлтгэл нь хангагдаад явж байх нь уг нь чухал. Тэгээд энэ асуудлуудын хэрэгжилт ямар түвшинд байгаа, түүгээрээ хэрэгжээд явж байгаа юм уу төлөвлөгөө гарчихсан эсвэл арай болоогүй байгаа юм уу гэж бодож байна. Тэгээд энийг яах вэ би зарчмын зөрүүтэй санал гээд нөгөө хөтөлбөрт байгаагүй 26 оны төлөвлөгөөнд байгаагүй учир оруулсан юм. Гэхдээ ер нь ямар түвшинд, яаж явж байгаа талаар эхлээд асуучих нь зүй юм болов уу гэж бодсон юм.

Ч.Ундрам: Бид Боловсролын багц хуулийг 2023 онд батлахдаа англи хэлийг албан ёсны боловсролын гадаад хэл гээд зарласан. Энэ маань person хөтөлбөрөөр хэрэгжээд явж байгаа. Шинэ сургалтын хөтөлбөр бас ингээд боловсруулагдаад явж байгаа. Тэгэхээр саяын Баярмаа гишүүний асуултад Батжаргал дарга 6 номер хариулья.

Х.Батжаргал: Өмнөх гишүүдийн асуусан асуултад хариулах үеэр хөтөлбөрийн шинэчлэлийн ажил явагдаж байгаа гээд яригдсан, мэдээлэл өгсөн байгаа. Тэгэхээр энэ хөтөлбөрийн шинэчлэлийн ажлын хүрээнд таны асуусан асуултын хариулт болох энэ бэлтгэл ажлууд хиймэл оюун ухаан, компьютерын ухаан, энэ шинэ тутам хэрэгцээ шаардлага болж шаардагдаж байгаа энэ агуулгуудыг хөтөлбөрт шингээгээд бэлтгэл ажил хангагдаад явж байгаа. Гагцхүү энийг нэвтрүүлнэ гэдэг маань батлагдсан хөтөлбөрийнхөө дагуу сурах бичиг хэвлэгдэх ёстой. Хэвлэгдэх процесс маань өөрөө тодорхой хуулийн цаглавартай, үе шаттай учраас тэр ажлууд үе шаттайгаар ингээд хийгдээд явна. Англи хэлний тухайд энэ ажил хөгжлийн жилийн төлөвлөгөөнд шинээр хийгдэх 26 онд шинээр хийгдэх ажил бол биш. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжээд хагас жил дөхөж байна. Тэгэхээр энэ хугацаанд хэрэгжээд явж байгаа ажил. Үргэлжлээд

урсгал зардлаараа буюу яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнийхөө дагуу 2026 онд тавигдаад, хийгдээд бид явна.

Гагцхүү жилийн төлөвлөгөө дээр хөрөнгө оруулалтын шинжтэй томоохон зардлууд нь суусан учраас энэ ажил урсгал зардлынхаа хүрээнд хийгдэж байгаа ажил гэдэг утгаараа тухайлан зүйл, заалт болж ороогүй. Зүгээр мэдээж гишүүний тавьсан асуудал бол зарчмын зөрүүтэй саналаар бүрэн эрхийнхээ хүрээнд ингээд орж ирэхэд угаасаа хэрэгжээд явж байгаа ажил учраас үргэлжлээд явна гэж хэлэх байна.

Тухайлбал англи хэл дээр, англи сая Байнгын хорооны дарга хэлсэн pearson хөтөлбөр зөвхөн ерөнхий боловсрол төдийгүй дээд сургууль, дээд боловсролын түвшинд Англи хэл дээр хичээл заах энэ хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажлыг 20 хувьд хүргэх энэ ажил явагдаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол дээр энэ pearson хөтөлбөрийн дагуу мэдээлэл технологийн хичээлийг англи хэл дээр явагдах энэ ажлууд хийгдээд, хэрэгжээд, туршигдаад явж байгаа. Туршилтын ажлууд энэ 2025 он хийгдээд явж байгаа. Тэгэхээр 26 оны ажил бол шинэ ажил биш, үргэлжлэл ажил гэж хэлэх байна.

Ч.Ундрам: Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: Тэгвэл ямар ч байсан сургалтын хөтөлбөр шинэчлэгдэж байгаа юм байна, шинэчлэгдэх ажил нь хийгдэж байгаа юм байна. Хэзээ дуусах юм бол, сурах бичгүүд нь хэзээ гарах юм бол, яг хэзээнээс энэ шинээр сургалтын хөтөлбөр нь хэрэгжиж, хичээлийн жилээс хэрэгжиж эхлэх юм бол? Мөн түүнчлэн саяын яг түрүүний асуусан тэр Англи хэл орох жил нь хэзээнээс юм бэ? 2027 оны хичээлийн жил юм уу, 26 оны хичээл хичээлийн жил юм уу гээд энэ чинь нэг энэ хууль батлагдаад багагүй хугацаа өнгөрч байгаа юм чинь бэлтгэл ажил нь явж байгаа юм байна тийм ээ? Гэхдээ яг тодорхой тийм төлөвлөсөн тэдэн хэдэн оноос гэсэн зүйл байгаа юм болов уу? Баярлалаа.

Ч.Ундрам: Батжаргал дарга яг тодорхой хариул даа товч.

Х.Батжаргал: Гишүүний нэмэлт тодруулгад нэмж хариулъя. 2025 он, 25-аас 26 оны хичээлийн жил буюу 9 сарын 1-нээс 3 дугаар ангиас Англи хэлний хичээл орж эхэлнэ. Энэ бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа, бэлэн байдал нь хангагдаад. Хөтөлбөр үндсэндээ pearson гэж одоо хэрэгжээд явж байгаа хөтөлбөрөөс, хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг үргэлжлүүлж хангаад явна гэсэн үг. Үе шаттайгаар явагдана хөтөлбөрийн шинэчлэлийн ажил. Эхний ээлжид 2025 онд бэлтгэл ажил хангагдаад явж байгаа нь сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол буюу 1, 2 дугаар анги дээр энэ хөтөлбөрийн бэлтгэл ажил үндсэндээ бэлэн болоод, хөтөлбөр туршигдаад ингээд явж байгаа. 2026-аас 27 оны хичээлийн жилд бүрэн суурь боловсролын түвшинд энэ бэлтгэл ажлууд яг адилхан үе шаттайгаар туршигдаад, тэгээд сурах бичгүүд нь хэвлэгдээд ингээд явна. Хуульд маш тодорхой.../минут дуусав/

Ч.Ундрам: Сая энэ ирэх хичээлийн жилээс 1-ээс 3 дугаар анги шинэ хөтөлбөрөөрөө явна гэж хэлсэн үү та? 6 номер хариул даа.

Х.Батжаргал: Шинэ хичээлийн жилээс Англи хэлний хуулийн хэрэгжилт хангагдаад, 3 дугаар ангиас ороод явна. Сургуулийн өмнөх боловсрол буюу

цэцэрлэг дээр энэ хөтөлбөрийн шинэчлэл хийгдэж байгаа. Энэ ажил шинэ хичээлийн жилээс хэрэгжээд явна. 1, 2 дугаар ангийн хөтөлбөрийн шинэчлэл буюу хөтөлбөр бол одоо бэлэн болчихно. Одоо ингээд мэргэжлийн зөвлөлүүдээр хэлэлцэгдээд явж байгаа. Гагцхүү сурах бичгийг хэвлүүлж нэвтрүүлэх ажилд үе шаттай хугацаа орохоор байгаа. Энийг яг 9 сарын 1-нээс сурах бичгийн хэвлэлт бэлэн болж, нэвтэрнэ гэдгийг энд хэлэхэд арай эрт байгаа. Сурах бичгийн боловсруулалт.../үг тасрав/

Ч.Ундрам: Сурах бичгээ шинээр зохиож байгаа учраас цаг авч байгаа биз дээ?

Х.Батжаргал: Яг үнэн.

Ч.Ундрам: Зургийг нь зурахаас авхуулаад бүх юм.

Х.Батжаргал: Зураг зурахаас гадна дахиад нөгөө тендер зохион байгуулалтын ажлууд гээд үе шаттай ажлууд 9 сарын 1-нд амжих гэдгийг энд хэлэхэд эрт байгаа.

Ч.Ундрам: Тэгэхдээ миний өрөөнд бага ангийн хөтөлбөрийн бүх сурах бичиг чинь байж байгаа шүү дээ. Би бүгдийг нь нэг нэгэнгүй үзээд байж байгаа. Энийгээ засаж сайжруулахад цаг орох гээд байгаа юм уу? 6 номер хариулъя.

Х.Батжаргал: Тийм. Таны өрөөнд Байнгын хорооны гишүүдэд хүргэгдчихсэн байгаа энэ хөтөлбөрийн туршилт хийгдээд явж байгаа энэ хувилбарыг гишүүдэд хүргэсэн байгаа. Энэ туршилт хийгдээд, хөтөлбөр боловсрогдоод, энийгээ эргэж дахин сайжруулаад хуульд угаасаа туршилт хийгдэх ёстой гэсэн хувилбар байгаа. Тэгээд энийгээ сурах бичиг болгож ахиж боловсруулах энэ асуудлыг хуульчилчихсан хуулийн хугацаатай байгаа учраас хөтөлбөрөө, хөтөлбөрийнхөө дагуу сурах бичгээ боловсруулах ажил үргэлжлээд явагдана. Хөтөлбөрөө сурах бичиг болгоно. Сурах бичиг болгохдоо сурах бичиг нь ямар бүрэлдэхүүнтэй, яаж зохион байгуулагдах вэ, ямар хугацаанд бэлтгэл ажлууд нь тендер, сонгон шалгаруулалт зохион байгуулалт хийгдэх вэ гэдгийг хуульчилсан учраас тэр хуулийн хугацаа нь өөрөө 9 сарын 1 гэхэд арай амжихааргүй байна.

Ч.Ундрам: Энд хариуцлагатайгаар хэлэхэд манай Боловсролын яамныхан боловсролын шинэчлэлийн хамгийн гол цөм нь хөтөлбөрийн шинэчлэл шүү. Энэ хөтөлбөрийг маш том ажлын хэсэг гараад боловсруулж, туршаад ингээд явж байгаа. Энд жинхэнэ Монгол хар хайрцгийн бодлого, Монгол хүмүүсийг бэлдэх энэ асуудал чинь орж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн алдаа мадаггүй, Монгол Улсынхаа эрх ашгийг 1 дүгээрт тавьж, энэ хэл соёл, түүх, уламжлал, мөн шинэ цаг үетэй хөл нийлүүлэх асуудал тэр компьютер, хиймэл оюун ухаан, Англи хэл гээд бүх талаас нь та хэд маань харж, мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй хамтарч баталж байж тэр сурах бичгээ хэвлэнэ шүү. Энэ сурах бичиг чинь өөрөө жендерийн, хүний эрхийн мэдрэмжтэй байх ёстой гээд ингээд олон талын юм байгаа.

Өмнө нь сурах бичиг дээр янз бүрийн сонин, сонин агуулга орчихсон байна, ингэчихсэн байна, тэгчихсэн байна гээд маш олон ард түмний эгдүүцлийг хүргэсэн юмнууд байсан. Тэгэхээр одоо ялангуяа энэ түүхийн хичээл, соёл уламжлалын

агуулга эд нар дээр маш сайн анхаарах ёстой. Математикийн хичээл байсан ч гэсэн өгүүлбэртэй бодлого нь дотроо Монгол түүх, тэр уламжлалаа шингээсэн өгүүлбэртэй байх ёстой гэх мэтчилэн олон талаас нь анхаарах ёстой шүү гэдгийг дахин, дахин сануулж байгааг та бүхэн мэдэж байгаа. Тэгээд энэ бол маш том хариуцлагын асуудал шүү гэж хэлмээр байна. Гишүүд асуулт асууж, нэг тодруулах юм байна. Баярмаа гишүүн тодруулъя.

Ж.Баярмаа: Тэгэхээр мэдээж энэ ач холбогдлыг бол, ач холбогдлыг нь бид бүгд маш сайн ойлгож байгаа. Энэ шинэ зуунд бол ажил мэргэжлийн хэрэгцээ шаардлага шал өөр болчихсон. Бүтээлч сэтгэлгээтэй хүүхдүүд хэрэгтэй байна, төрж гарах хэрэгтэй байна, төгсөж гарах хэрэгтэй байна, инновацлаг хүүхдүүд гарах хэрэгтэй байна, цогц анализ синтез хийдэг ийм чадвартай хүүхдүүд болж гарах хэрэгтэй байна. 1 оффисын программ дээр нэг өлхөн ажиллачихдаг хүүхдүүд гарч ирэх хэрэгтэй байна. Өөрсдөө кодоо бичдэг, өөрсдөө кодоо бичдэг ийм чадвар бүхий хүүхдүүд гарна гэдэг нь эргээд үндэсний аюулгүй байдал, үндэсний дархлаатай маш их холбоотой. Тэгэхээр дахиад нэг асуулт эндээс ургаж байгаа нь энэ ажил мэргэжлийн хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж байгаа дээр судалгаа байгаад тэр цөм хөтөлбөр, их дээд сургуулийн хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлтэй уялдаад, түүн дээр ер нь ингэж ажиллаж байгаа, тэр чиглэлийг нь өөрчлөх гэж байгаа ч байдаг юм уу тийм ямар нэгэн хийгдэж байгаа зүйл юу байгаа юм?

Ч.Ундрам: Батжаргал дарга 6 номер хариулъя.

Х.Батжаргал: Гишүүний нэмэлт асуултад тодруулъя. Энэ хөтөлбөрийн шинэчлэлийн гол зорилго нь илүү мэдлэгжүүлэхийн хажуугаар чадваржуулах асуудал байгаа. Гол нь гол, гол ур чадваруудыг эзэмшиж, хүүхдүүд ерөнхий боловсролынхоо эзэмших энэ явцдаа олон төрлийн чадваруудыг эзэмшиж бий болгох энэ зорилгыг явуулж байгаа.

Таны асуултад гарсан энэ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох энэ чиглэл бол хөдөлмөрийн зах зээлийнхээ эрэлттэй уялдаад мэдээж дээд боловсролын тухайд цаг үе тутамд байнга шинэчлэгдээд, шинэ хөтөлбөрөө нэмэгдүүлж, жил болгон элсэлтээ аваад ингээд явчхаж байгаа. Ерөнхий боловсролын энэ хөтөлбөрийн хувьд илүү чадвар луугаа чиглэсэн энэ чадамжуудыг л төгс бий болгох энэ суурь судалгаа энэ хөтөлбөрийн шинэчлэлийн явцад бүгд хийгдээд явж байгаа. Гишүүн, Байнгын хорооны даргын хэлсэнчлэн маш олон талын оролцоотой энэ ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Зөвхөн Боловсролын яамд.../минут дуусав/

Ч.Ундрам: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Саранчулуун гишүүн, үгээ дарсан уу? Саранчулуун гишүүнээр тасаллаа. Бум-Очир гишүүн үг хэлье. Галбадрах гишүүн үг хэлье.

Ж.Галбадрах: Сая би нэг асуултдаа хариулт авч чадаагүй. Тэгээд тэрийгээ асууя гээд байгаа. Тэгэхдээ үг хэлж байгаа учраас дараа нь тусад нь авч болно. Эдийн засаг, хөгжлийн яамнаас тэр ипотекийн зээлд хамруулах талаар багш нарын тэр бодлогыг нь илүү дэлгэрэнгүй асууя гэж бодож байна.

Саяын Батжаргал Төрийн нарийны хариулаад байгаа тэр англи хэл эхлэх асуудал 100 сургууль дээр өнгөрсөн хичээлийн жил эхэлсэн гэж сонсож байсан,

100 сургууль дээр. Тэгээд тэр сургуулиуд дээр ер нь ямар явсан юм бэ гэдгийг би Баярмаа гишүүний асуугаад байгаа шиг тийм нарийн юм руу орж сая нэмж тэрийг бас нэг тодруулж мэдмээр байгаа, энэ талаараа дараа нь тодруулъя.

Ер нь энэ манай Их Хурлын гишүүд дотор боловсролын салбарын төлөөлөл Ардчилсан нам дотор манай Мөнхтуяа гишүүн байж байна. Эвсэл дотор Ундраа гишүүн байж байна. Манай нам дотор Хэрлэн гишүүн, Бум-Очир гишүүн гээд бид ингээд дандаа багш хийж байсан ийм хүмүүс байгаа. Тэгээд багш нарын буюу их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн тэр зовлон, жаргалыг сайн мэдэх хүмүүс байгаа учраас бүгдээрээ нэг амьдралтай юм хийхгүй бол зүгээр нэг ийм цаасан дээр тэмдэглэсэн шинэчлэл гэдэг юм уу, цаасан дээр тэмдэглэсэн зүйлийг хийхээс нэлээн тийм татгалзаад, яг ингээд бодитой, хэдэн талаасаа яриад, сая бид тэр хүртээмжийн тал дээр Боловсролын яам, Нийслэл, Сангийн яам ингээд 3 талаасаа уулзаад ингээд яриад байхаар ажлууд нэлээн тийм юутай явдаг юм байна лээ бүтээмжтэй. Хэдэн талаасаа уулзаад яриад, харилцан буулт хийгээд гэдэг юм уу өөрсдийнхөө өнцгийг гаргаж байгаа санаагаа ингээд сайхан тайлбарлаад яриад явах нь их зохимжтой. Тэгэхээр энэ тал дээр хэдүүлээ боловсролынхоо жилийг угтаад хамтдаа их сайхан уулзах тийм цагуудыг гаргая.

Би жишээ нь энд ингээд илтгэл тавих гэж байна л даа, өнөөдөр мэдээлэл өгөх гэж байна. Тэгээд энэ мэдээллээ ч гэсэн Эдийн засаг, хөгжлийн яаман дээр очиж танилцуулаагүй байгаа. Тийм цаг гаргавал нэг очоод танилцуулаад явъя гэсэн ийм байгаа. Тэгэхээр аль, аль талдаа мөн чанараар нь энэ гишүүдийнхээ энэ дотор нь, гал тогоонд нь чанагдаж байсан хүмүүсийнхээ санааг сайн тусгаад, ингээд хамтраад ажиллаад явъя гэдгийг хэлэх байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Саяын үг дээр маш чухал нэг юм дурдагдаагүй өнгөрснийг саначихлаа. Хөдөө орон нутагт багш очоод ажиллая гэхээр ерөөсөө байр сав байхгүй байна. Тийм учраас ипотекийн зээл, ялангуяа энэ боловсролын салбарт багш нарт шийдэж өгөхгүй бол энэ багшийн дутагдал ерөөсөө арилахгүй байгаа. Тэгэхээр энийг заавал энэ ипотекийн зээлтэй холбоотой бодлогодоо тусгамаар байгаа шүү. Дараагийн үг хэлэх гишүүн Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: 1 маш хэцүү сэдвээр ярья. Энэ сэдвийг хөндөхгүй бол ерөөсөө болохгүй. Нөгөө багш нарын цалин. Тэгээд 26 онд боловсролын жил болгож зарлаж байна. Зөв. Гэхдээ энэ төсөв төлөвлөгөө элдэв юмыг харахад багш нарын цалин харамсалтай нь нэмэгдэхгүй юм шиг байна. Нөгөө хуульд байгаа инфляцын 6 хувиараа л нэмэгдэх байх. Тэгэхээр бид яг багш нар маань биднээс юу хүлээж байгаа вэ гэхээр боловсролын жил болж зарлаж байгаа юм чинь багш нарын нэг цалин хөлс, ахуй амьдрал дээшлэх байх гэж ийм хүлээлт олон нийтийн дунд, багш нарын дунд байгаа шүү дээ. Бид тэгээд юу гэж хэлэх юм бэ? Уучлаарай улсын төсөв хүрэхгүй гэдэг нөгөө юмаа хэлээд сууж байх юм уу? Яг бодит байдал дээр тийм шүү дээ. Боловсролын жил болгож зарлачхаад багш нарынхаа цалинг нэмж чадахгүй байгаа гэдэг ийм асуудал дээр очно.

Багш нарын цалин нэмэх тухай асуудал ярихаар цалин ярилаа гэдэг, ярихаас өөр арга байх байхгүй байна шүү дээ, одоо яах юм бэ? Үнэндээ багш нар дутагдалтай байгаа. Сая Галбадрах гишүүн хэлж байна, Мөнхтуяа гишүүн энэ тэр зөндөө хэлсэн. Багш нар байгаа шүү дээ Монголд. Монголд биш нөгөөдүүл маань Солонгост байгаа ихэнх нь тов тодорхой шүү дээ. Сая нэлээд олон гишүүд хэллээ. Энэ багш мэргэжил эзэмшчихсэн, тэгээд эсхүл дөнгөж төгсөөд багшийн ажлыг

хийхгүй байгаа тоо өндөр байгаа. Яагаад хийхгүй байгаа юм тов тодорхой шүү дээ. Би өмнө нь ч хэлж байсан ажлын ачаалал их, цалин бага, энэ ажлаас халширдаг. Тэгээд яг үнэндээ бидэнд байгаа цөөхөн боломжуудын нэг нь багш нарынхаа цалинг нэмж байж, энэ ажлын байранд нь багш нараа буцааж уриалж авчрах ийм зүйл шүү дээ. Тэгэхээр энийг бид юу гэж тайлбарлаж, юу гэж ойлгох юм бэ, олон нийт маань юу гэж ойлгох юм бэ? Маш их хүлээлт үүсчихсэн байгаа. Тэгэхээр энэ асуудал бол эрт, хожуу хэзээ нэгэн цагт бидэнд бүгдэнд нь яригдах байх.

Мэдээж улсын төсөв хэцүү байгаа, эдийн засаг хэцүү байгаа гэдгийг ойлгож байна. Тийм учраас би нэг хэцүү асуудлыг ярихгүй өнгөрч болохгүй, ярихад хэцүү нэг ийм зүйл байгаад байна шүү дээ. Энийгээ яах ёстой юм бэ бид? Ингээд ярихаар нэг хэдэн гишүүд нь багш нарын цалингаас өөр юм ярьдаггүй гэдэг юм ярьдаг. Тэгээд бүр сүүлдээ ярихаар ярьсан хэрэгт орох гээд байгаа ч юм шиг. Үгүй ээ ярихгүй гэтэл энэ асуудлыг шийдэж бид ард нь гарч чадахгүй ийм байдалтай байгаад байна шүү дээ. Тэгэхээр ямар нэгэн байдлаар багш нарынхаа цалинг бага ч болсон нэмэх арга байдаггүй юм уу, 6 хувиасаа гадна шүү? Инфляц энэ тэр бол тэртээ тэргүй инфляцаараа ороод ирнэ. Энийг хаана хаанаа бодмоор байна. Яах ёстой юм бэ?

Яагаад гэхээр өнгөрсөн жилүүдэд овоо нэмэгдээд, багш нарын нэг итгэх үнэмшил, итгэл үнэмшил нэмэгдээд, магадгүй энэ багш болох залуучуудын тоо ч нэмэгдэх тийм хандлага тодорхой хэмжээгээр гарсан гэж би ойлгодог. Гэтэл ингээд эргээд нөгөө бид үе шаттайгаар тогтмол нэмж байх ёстой болов уу гэж би бодож байгаа юм. Их, бага дүүрч, өөрсдийнхөө боломжоор. Тэгж байж энэ салбарт чинь нэг салхи орж, багш нар юм уу, багш болох гэж байгаа залуучуудад урам зориг өгөх байх л даа. Тийм учраас энийг хаана хаанаа бид бүгдээрээ л бодмоор санагдаж байгаа юм шүү гэдгийг онцлон хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Ч.Ундрам: Ер нь цаашид манай ЗГ төгрөгийн ханшийг чангаруулбал энэ нийт төрийн албан хаагчдын чинь цалин мянган доллар болох хэмжээнд хүргэхүйц болговол хамгийн зөв бодлого гэж хараад л байгаа юм. Тэгээд энэ чухал асуудал хэллээ. Дараагийн үг хэлэх гишүүн Саранчулуун.

О.Саранчулуун: Үндэсний статистикийн хорооны мэдээллээр өнгөрсөн 10 жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдүүдийн тоо 2 дахин нэмэгдсэн байхад, ерөнхий боловсролын сургуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо 2 дахин буурсан байна. Энэ чинь Үндсэн хуулийнхаа 16.7 сурч боловсрох эрх нь манай энэ нөхцөл биелэхгүй байна л гэсэн үг. Хүүхдүүд яагаад ингээд сургуульд хамрагдаж чадахгүй байгаа вэ гэсэн чинь 4 том асуудал байна. 1 дүгээрт нь сургуулийн орчин байна. Хуучин сургууль, шинэ сурлагын орчин, бодит орчин байна. Хоёрдугаарх нь багш бэлтгэгдээгүй. Багш гэдэг дотор юу байгаа вэ гэхээр багшийн заах арга зүй хүртээмжтэй биш байна гэсэн үг. Монгол хэл, математик, физик ч байдаг юм уу бүх хичээлийг заахдаа би удаан ойлгодог Балдан гэдэг хүүхдэдээ заах арга багш эзэмшээгүй байна, бусад 11 хүүхдэд заадаг аргаараа заагаад, нөгөө хүүхдэдээ заах арга зүй болоогүй байна л гэсэн үг. Нөгөө талдаа багшийн заах арга зүйн хүртээмж дээр нэмэгдээд сургалтын хэрэгсэл яригдаж байгаа. Сурах бичиг шинэчлэгдэж байгаа хүртээмжтэй хувилбар байгаа гэж би амаар олон удаа сонссон. Одоо гартаа барьж, нүдэндээ харсан юм харагдахгүй байна. Энийгээ сайжруулахгүй бол энэнээс болоод байна.

Дараагийн шалтгаан нь ялгаварлан гадуурхагдаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ оруулах гэхлээр багш нь ойлголтгүй, сурагчид нь ойлголтгүй учраас ялгаварлан гадуурхалд өртөж байгаа учраас тэр хүүхдүүд сургуульд явах, ахих, сурах, ахижхичээлдээ явах хүсэлгүй болж байгаа учраас энэ нөлөөлж байна гэсэн байгаа. Ингээд амиа хорлох оролдлого хийсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зөндөө байна.

Дараагийн саад бэрхшээл нь нэг ангид байх хүүхдийн тоо ба хэдэн хүүхэдтэй байвал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг, хүүхдийг байлгах юм бэ гэдэг тэр харьцааг нарийвчлан шийдээгүй байна. Энийгээ шийдээгүйн улмаас багш өнөөдөр 20 хүүхэдтэйгээ ажиллах уу, нөгөө удаан суралцаж байгаа нэг хүүхэдтэйгээ ажиллах уу гэдэг сонголтын өмнө тулгараад, багшид ачаалал ирээд байна гэсэн ийм асуудал байна. Энэ 4 асуудлаар хэдүүлээ зорилго тавьж байгаад, нэг бүрчлэн дата гаргаж авмаар байна. Яг энэ 4 асуудлаар. Хэдэн багш өнөөдөр хүртээмжтэй заах арга зүйтэй болсон бэ, хэдэн сургуулийн барилга хүртээмжтэй болсон бэ, нэг ангид байх хүүхдийн тоогоо яаж зохицуулж байгаа вэ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд яаж байгаа вэ гэдэг тоотой барьж байгаад дараагийн босгыг ингэнэ гэдэг ийм төлөвлөгөөг би энэ өргөн мэдүүлсэн төслөөс харахыг хүсэж байна. Гэтэл би ерөөсөө энэ дээр нарийн юм байхгүй байна.

Дараагийн асуудал Боловсролын зээлийн сангийн журмын асуудлаар бид ажилласан. Эргэж харахгүй болохгүй 2 асуудал байна. Нэгдүгээрх нь 3 хуулийн заалт давсан 1 журам байгаад байна. Тэр нь юу вэ гэхээр Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.6-д элсэлтийн шалгалтад тэнцэж дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр сургалтын төлбөрийг Боловсролын зээлийн сан хариуцна гэж байгаа. Боловсролын ерөнхий хуулийн 11.3-даа бас заачихсан байгаа. Гэтэл өнөөдөр энэ журам нь яг энэ нөхцөлийг хангаад, би энэ дэмжлэгийг авъя гэхээр журам нь өөрөө эндээсээ мэргэжлийн болон техникийн гэдгийг нь хасаад хаячихсан журам байгаад байгаа байхгүй юу. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өнөөдөр мэргэжлийн болон техникийн байтугай бакалавр, магистр, докторт сурахад хэцүү байдаг шүү дээ, 10 жилд сурахад ч хэцүү байна. Би бол үйл тамаа үзэж байж өнөөдөр нэг эрдмийн зэрэг олж авсан, 20 жил зүтгэж байж. Энэ хугацаанд би зөндөө өвдөж гэмтэж байж нэг юм боловсролтой болсон. Ийм болоход хүн их хүнд замыг туулдаг. Тэгэхээр бүгдээрээ энэ журмыг хараад, энэ боловсролынх нь босгыг нь энэ хуульд зааснаар нь болгомоор байна. Энэ дээр анхаарч өгөөч.

Дараагийнх нь дэлхийн топ гэдэг ангилал дотор чинь нөгөө хэл засалч, хөдөлгөөн засалч, протез ортопедийн техникч, дохионы орчуулагч нар нь хэдэн, хэр хугацаанд байгаа гэдэг тоог харж байж оруулмаар байна. Топ, топ гээд байдаг яг энэ мэргэжлээр суръя гэхээр энэ.../минут дуусав/

Ч.Ундрам: Эрдэнэбат гишүүн үг хэлье.

С.Эрдэнэбат: Боловсрол ядуурлыг болон ялгаатай байдлыг арилгах хамгийн гол бодлогын хэрэгсэл байдаг. Тийм учраас энэ боловсролын ялгаа гэдэг алсдаа Монгол Улсын нийгмийн баян, хоосны ялгаатай ч шууд холбоотой. Тийм учраас боловсролын салбарыг энэ ялгаатай байдлыг хэт их бид бий болгомооргүй байгаа юм. Тийм учраас өнөөдөр захын хороололд байгаа, эсхүл нэг сумд байгаа

сургуулийн сууж байгаа танхимаас нь авхуулаад, сандлаас нь авхуулаад, үзэж байгаа компьютер, зааж байгаа багшаас нь авхуулаад энэ манай Зайсан хавиар байгаа өндөр төлбөртэй сургуулиудын боловсролын чанарын ялгаа холдох тусмаа л бид нийгмийн ялгарлыг бий болгоно. Тэгээд заримдаа энэ төрийн өндөр албан тушаалтнууд болон ер нь төрийн бодлого шийдвэр гаргаж байгаа хүмүүс нөгөө улсын сургуульд хүүхдээ сургана гэдэг хууль санаачилчихмаар санагдаад байгаа юм.

Яагаад энийг хэлж байна вэ гэхээр өнөөдөр 10 сая төгрөгийн цалинтай багшаар хичээл заалгаж байгаа хүүхэд, 1 сая 500 мянган төгрөгийн хичээл заалгаж байгаа хүүхдийн хооронд ирээдүйд өрсөлдөнө л дөө. Тэгээд энэ өрсөлдөөн бол нөгөө гарааны тэгш боломж байхгүй ийм хүч тэнцвэргүй ийм өрсөлдөөн болдог. Тийм учраас бид ийм нийгмийг бий болгомооргүй байгаа гэдэг үүднээс ирэх жилийг боловсролын жил болгоё, боловсролын ялгааг арилгах, багшийн дутагдал, сургуулийн дутагдал юм хийх гэдэг дээр бол байна. Тийм учраас багшийг яриад байгаа юм. Түрүүн манай Галбадрах багш, Бум-Очир гишүүн энэ тэр бол яах аргагүй ярихаас өөр арга байхгүй. Багшийн цалин гээд ярингуут нь онцгойлон нэг салбарыг авч үзэхгүй гэж яриад байгаа юм, ингэмээргүй байгаа юм. Энэ чинь бусад салбарууддаа шууд нөлөөлдөг хамгийн суурь салбар байхгүй юу. Багш нартайгаа, хүүхдүүдтэйгээ барьцдаг өөр салбарын хүмүүс гэж байхгүй шүү дээ. Наанаа багш цалин авах гээд байгаа боловч цаанаа тэр хүүхдэд нь тогтвортой. Сүүлийн үед хувийн сургуулиуд руу, эсхүл өөр салбар луу, гадаад руу, эсхүл төв рүү гэсэн ийм 4 урсгалаар багш нар урсаж байгаа. Энэний цаана ирээдүйд хичээлийн хоцрогдол, чанаргүй сурагчдын л тоо нэмэгдэнэ гэсэн үг. Тийм учраас энэ тал дээр бид энэ боловсролын жил болж байгаатай холбоотой дорвитой шийд гаргачихмаар байна Сангийн яамныхан. Энийг Засгийн тэргүүнүүд ч гэсэн ер нь ойлгох хэрэгтэй болов уу гэж бодож байна.

2 дугаарт энэ гүйцэтгэлийн үнэлгээ гээд. Уг нь зөв, гэхдээ буруу хэмжвэл энэ өөрөө маш буруу зүйл рүү дагуулж байна. Багш нар гүйцэтгэлийнхээ үнэлгээг авахын тулд, тэр хамт олон авахын тулд өөрөө өөрсдийгөө хуурах хэмжээ рүү орох ийм юм руу орж байгаа юм байна лээ. Би бол багш нартай их ойрхон байдаг хүн. Дүнг нь муу тавиад байхаар эцэг, эхчүүд нь багшид нь үнэлэх үнэлгээг нь муу тавьдаг учраас муу цалин авна гээд. Тэгэхээр багш өөрөө өндөр урамшуулал авахын тулд дүнг нь өргөж тавихаас өөр аргагүй, өөрийгөө хуурдаг байхгүй юу ийм юм руу орж байгаа. Хамт олны уур амьсгал өөр болж байна. Энэ нөгөө өндөр цалин, өндөр үнэлгээ авдаг багш, муу багш, хавь орчных нь үнэлгээ өөрсдөөс нь хамаарахгүйгээр тэр шороо тоос эргэлдэж байхад тэр сургуулийг хэзээ ч онц үнэлэхгүй нь лавтай байх л даа. Орчны үнэлгээ гэдэг юман дээрээ. Тийм учраас энэ гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг юмандаа энэ жил нэг цэг болгож, болбол болгоод, болгохгүй бол тэгээд тэр үндсэн цалин руу нь тэр юмыг нь оруулаад шийдэх нэг яахгүй бол, энэнээс чинь болж яг үнэнийг хэлэхэд эргээд энэ сурагчдын юутай бол маш их сөрөг үр дагавруудыг авчирч ирж байна.

Анги даалт гэхэд анги даах багш олдохгүй болчихсон юм байна лээ. 10-хан хувийн нэмэгдэлтэй, тэр ангийн хүүхдийн нэг асуудал болоход тэр багш дээр бараг эрүүгийн ял хариуцлага тооцох нь холгүй ийм болчихсон учраас. Бидний үед анги даасан багшийн л хүмүүжлээр өсөж хүмүүжиж, эцэг, эхтэй хамгийн ойрхон ажилладаг байсан. Тэгэхээр энэнээс болоод анги даах багш олдохгүй болчихсон юм байна. Соёл бол үндэсний дархлаа. Соёлоо бид хэзээ ч хаяж болохгүй. Ийм саналуудыг хэлмээр байна.

Ч.Ундрам: Гишүүд үг хэлж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал байхгүй болсон тийм ээ? Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. Тийм Учраас Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе. Тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд уншиж танилцуулна. Хэн танилцуулах вэ саналаараа? Эдийн засгийн байнгын хороонд санал, дүгнэлтийг Эрдэнэбат гишүүн танилцуулна.

13.26 цаг

Хоёр.Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонсох

Дараагийн асуудал Улсын Их Хурлын даргын 2024 оны 114 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Галбадрах танилцуулна.

Ж.Галбадрах: Энэ бас завтай сонсож болно шүү цаг байвал, болох билүү, үгүй билүү юу, presentation-аа өгчих үү?

Ч.Ундрам: Презентацыг нь гаргаад өгөөрэй.

Ж.Галбадрах: Энэ дээр гаргачихвал би энийг харах гэж. Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцаас та бүхэндээ мэдээлэл өгье. Энэ яагаад явахаа больчихов. Ийм агуулгаар ярья. Ажлын хэсгийнхээ хийгдсэн ажлын талаар товчхон яриад, 3 судалгаа хийсэн байгаа юм. Барилгын хүртээмж, багшийн хомсдол, багшийн ажлын байрны зураглалын талаар гэсэн юугаар хийе.

Ажлын хэсэг маань 9 сарын 5-ны 114 дүгээр захирамжаар байгуулагдаад, 20 гишүүнтэй ийм том ажлын хэсэг байгаа. Тэгээд яг ажлын хэсгийнхээ үүргийг хэлбэл Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцах, бүх шатын сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах асуудлыг судалж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгаа. Тэгээд ажлын хэсгийн үндсэн чиглэл нь сая дурдсанчлан сургуулийн барилгын хүртээмжээ үзье, тэгээд багшийн хүрэлцээ, сургуулийн менежмент гээд удирдамжаа гаргаад, ажлын төлөвлөгөөг тэнд орсон сая нэр бүхий манай энэ дотроос ч гэсэн хэд хэдэн гишүүд маань орсон байгаа. Ингээд бид хэд удирдамж, төлөвлөгөөгөө гаргаад ажиллаж байгаа. Ер нь бид ийм яам, ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн зэрэг байгууллагаас дараах мэдээллүүдийг сонссон.

Хууль батлагдсантай холбогдоод сургалтын хөтөлбөрийг шинэчилж байгаа явцын талаар, Ерөнхий хуулийг дагаж гарсан журам, тэдгээрийн хэрэгжилтийн талаар, МУБИС-ийн элсэлт, багшийн хомсдолыг бууруулах чиглэлээр хийж байгаа арга хэмжээ, МСҮТ-үүдийн элсэлт, энэ дандаа ирж ингэж бид очиж сонссон байгаа. Багш нарын нийгмийн асуудал болон цалин хөлс, урамшууллын талаар,

боловсролын хүртээмж, орчны стандарт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, багийн сургууль энэ тэр гээд ингээд сонссон. Мөн зүрх сэтгэлийн боловсролын хөтөлбөрийг судлаачаас сонсож байсан. Мөн цэцэрлэг, сургуулийн хүртээмж, бүлэг дүүргэлтийн талаар судалгааг судалгааны багтай хамтарч хийсэн. Тэгээд ажлын хэсэг одоогоор яг албан ёсоор 6 удаа хуралдсан, хэлэлцсэн асуудлууд нь энд ингээд байж байна. Та нарт ингээд өгчихсөн учраас та бүхэн маань ямар, ямар асуудлууд хэлэлцсэн юм бэ гэдгийг, их цаг бага байгаа, нэлээн олон слайд байгаа учраас яаж байна.

Хэлэлцүүлгийг олон байдлаар зохиосноос энэ том, нэлээн том олон хүн хамрагдсан нь Багануур дүүрэг дээр Сандаг-Очир гишүүнтэй, Хан-Уул дүүрэг дээр Алдаржавхлан гишүүнтэй багш нар, сургуулийн удирдлагуудын төлөөлөлтэйгөөр очиж хийсэн. Мөн МУБИС-ийн төгсөх ангийн оюутнуудад хүний багш байх, энэ яг багш гэдэг мэргэжлийн сайнхны талаар 2 удаа лекц уншсан байгаа. Тэгээд энд гишүүдээс маань оролцоод явдаг. Казахстан улсад гадаадад 24-өөс 25 онд 240 сургууль барьж байгаа гэдэг асуудал байсан учраас тэр comfort school гэдэг тав тухтай сургууль гэсэн үндэсний хөтөлбөрийг нь очиж үзсэн. 100 гаруй сургууль нь ашиглалтад орчихсон, тэгээд сургуулиудаар нь орж явж үзсэн. Тэгээд үнэхээр энэ улсаас сурах юм нь боловсролыг жинхэнэ зүгээр лоозон биш, жинхэнэ тэргүүлэх зэрэгт тавьж чадсан улс байна. Орон сууцын хотхон хороолол барих үедээ заавал сургууль, цэцэрлэгтэй байх газрыг нь тэр хангалттай чөлөөлж өгөөд ингээд хийдэг юм байна лээ. Доторх тэр ширээ, сандлаас эхлээд тавилгыг нь үндэсний үйлдвэрлэлээрээ хангадаг юм байна гэх маягийн. Тэгээд багшаар сурч байгаа эднүүд яг манайхтай адилхан зөвхөн төлбөр хөнгөлөхөөс гадна сар бүр стипенд буюу цалинтай оюутан болгодог юм байна. Багшийнхаа цалинг нэмж чадсан юм байна лээ. Төрийн албан дотроо хамгийн өндөрт тооцогддог гэж байна. Тэгээд бүлэг дүүргэлтийг 25-аар ингээд хувьчилж чадсан энэ тэр нь бид нарын суралцах ёстой зүйл байна лээ.

Тэгээд сургуулийн менежментийн талаар. Ерөөсөө боловсролын шинэчлэл гэдэг бол ерөөсөө л сургуулийн реформ байгаа. Тэгэхээр нэгж сургууль хэрхэн сайжрах талаар менежментийн талаар нь би өөрөө сургалтууд хийгээд явсан. Энэ Төв аймаг, Сэлэнгэ, Дархан, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгууд, Хан-Уул, Баянзүрх, алслагдсан 3 дүүрэг дээр очиж сургалтууд хийсэн. Тэгээд судлаач нарын багтай, хувь судлаач, мөн тийм судлаач нарын багтай хамтарч ажилласан. Оч, Дагмидмаа нартай хамтраад энэ хүртээмжийн талаар хийсэн байж байгаа. Дараа танилцуулна. Сүндарь, Ариунхишиг нартай хамтраад багшийн ачааллын зураглал хийж, нөхцөл байдлыг нь тодорхойлж, дүн шинжилгээ хийсэн. Дараа нь Алтансорттой хамтраад цэцэрлэгийн хөтөлбөрт зүрх сэтгэлийн боловсролыг нэвтрүүлэх талын судалгааг хийсэн. Тэгээд танилцуулгууд нь хийгдээд яваад байгаа. Бумдарь буюу Парламентын судалгааны төвдөө захиалга өгөөд, үр дүнгээ ингээд хүлээж байгаа.

Тэгээд сая би хэллээ. Ер нь боловсролынхоо салбарт хийх шинэчлэлийг эрэмбэ тогтоох ёстой гээд. Тэгээд энийг яаж тогтоох вэ гээд би өөрөө бүлэг дээрээ ч гэсэн ярьсан байж байгаа. Хувь хүний хэрэгцээний Маслоу-н шатлалын онол дээр тулгуурлаад ер нь анхдагч суурь хэрэгцээ гэвэл стандартын дагуу баригдсан барилга, багшлах боловсон хүчин юм. Тэгэхээр энийгээ хэрхэн хангагдсан юм бэ гэдэг судалгааг хийснээ танилцуулна одоо. Тэгээд дараа нь сайн боловсруулагдсан хөтөлбөр яах аргагүй хэлээд байгаа, энийг яам энэ тэр хийж байна. Ажлын хэсэг энэ рүү орж чадаагүй. Дараа нь сургуулийг бие даасан

байдалтай болгох буюу менежментийг нь сайжруулах тал дээр бид анхаарах ёстой. Тэгээд стандарт хангасан материаллаг бааз, лабораториор хангах, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, зүрх сэтгэлийн боловсрол, сургууль бүр соёлтой байх ёстой, зөв дадалтай байх ёстой, эцэг, эх, олон нийттэй нээлттэй байх, төгсөгчидтэйгөө эргэж холбогдож явж чадвал бид өнөөдөр үнэхээр аль ч улсын сургуулиас дутахгүй тийм жишигт хүрсэн сургууль болох юм гэсэн энэ эрэмбээс анхдагч суурь хэрэгцээгээ аваад үзээд явж байгаа юм.

Тэр 2 дахь судалгаан дээрээ барилгын хүртээмжийн талаар бид судалгаа хийсэн юм, ийм хүмүүстэй хийсэн. Нийтдээ 884 сургуулиас 704 төрийн сургууль байгаа, дандаа л төрийн сургуулийн асуудлыг энд ярьж байгаа. 797905 хүүхэд байгаагаас 721 мянга буюу 90,5 хувь нь төрийн сургуульдаа суралцаж байна. Багш нарын 86,7 хувь нь төрийн сургуульдаа байна гэсэн ийм тоо байна. Тэгээд энэ дотроосоо нэг анхаарал татаж байгаа нь ерөөсөө бүлэгт суралцаж байгаа хүүхдүүдийн мэдээллийг л гаргая гээд. Бид сая гишүүд маань ч хэлээд байна тэр сурах боломж ерөөсөө хангагдахгүй байгаа, сургалтын чанар яригдахгүй байгаа нь манайх чинь нэг ийм 2 туйлтай, бүүр 100 хүрэхгүй хүүхэдтэй сургууль олон байна. Тэгвэл нийтээрээ 6 мянга даваад гарчихсан сургууль ч байж байна. Тэгээд энэ дотроос нь 1 бүлэгт дүүргэх хүүхэд нь 40-өөс дээш гарсан хүүхдийг судлаад үзэхээр 40-өөс 49, манай стандартад ер нь 30-аас бага гээд заачихсан байгаа. Тэгж барилгаа барьдаг. 1 ангийн хэмжээнд 30-аас бага хүүхэд сурна гээд. Тэгээд 40 хүртэлх 39 хүртэлх хүүхдийг бид нүдээ аниад юм уу, тэвчье гэж бодоход, 40-өөс дээш хүүхэд дээр бид тэвчих боломж байхгүй юм байна гэдэг ийм өнцгөөс үзээд 40-өөс 49, 50-аас 59, 60-аас дээш гээд бүүр бүлэг дүүргэлтээр нь улсын хэмжээнд бүх задгай датаг нь аваад, нөгөө их өгөгдөл дээр нь тулгуурлаж аваад үзсэн. Тэгээд 214 мянган хүүхэд буюу 29,5 хувь нь ийм нөхцөлд сурч байна. Тэгээд ийм нөхцөлд сурч байгаа хүүхдэд сургалтын чанар ярих арга алга.

Нөгөө талаас сургууль даац нь манайх чинь 320, 640, 960 хүүхдийн суудалтай сургууль гэдэг. Энийг 2 дахин үржүүлээд 1800 хамгийн том сургуулийг нь, энэнээс дээшээ байхад сургалтын чанар алдагдаж байгаа. Сургууль хөл толгойгоо алдаж байгаа учраас 1800-аас дээш хүүхэдтэй сургуулиудыг нь түүж аваад үзэхээр 368 мянган хүүхэд буюу 5,8 хүүхэд нь сурч байгаа юм. Тал хувь нь ийм их даац нь хэтэрчихсэн сургуульд сураад, бие засах өрөө, биеийн тамирын заалнаас эхлээд, дугуйлан секц, оролт, гаралтаас эхлээд маш их хүндрэл учирдаг. Энэ бүх асуудлуудыг гаргаж ирээд, цаашдаа хүн амын өсөлт маань ямар байх юм бэ 25-аас 2050 он хүртэл ерөөсөө буурахгүй. Манайх төрөлт багасаад, хүүхэд буурна гэдэг бүр 2050 онд бид бүр сая гарсан хүүхэдтэй болох юм шүү. Одоо бол 800-гаад мянган хүүхэд байгаа бол 2050 онд сая болно, өснө гэдгийгээ бид мэдэж байх ёстой.

Тэгээд саяын энэ 40-өөс дээш хүүхэдтэй, 1800-аас дээш хүүхэдтэй ийм даац хэтэрсэн сургууль орон нутагт 39, нийслэлд 85 байгаа гэдэг тоог гаргаж ирсэн. Дээрээс нь тэгээд шинээр барих шаардлагатай сургууль гэдгийн тоог 150 хүүхдийн өргөтгөлд 300 хүүхэд орно, шууд 2 ээлжээр бүтэн орж байгаа, 320 хүүхдэд 600 хүүхэд, 640-д 1200, 960-д 1800 орно гээд хэдэн сургууль шинээр барих шаардлагатай вэ гэсэн 157 гэж гарсан. Гэхдээ 24, 25 оныхоо баригдсан төсвийг ингээд хараад 67 сургуулиа хасаад ирэхээр 108 сургууль буюу нийслэлд 84, орон нутагт 24 сургууль барих юм байна гээд энийгээ бид Сангийн яам, Боловсролын яамтай тохироод гаргаад ирчихсэн байж байгаа. Энд 1,6 их наяд төгрөг хэрэгтэй байна гэсэн тооцоог хийсэн юм байгаа юм.

Тэгээд шаардлагатай сургуулийнхаа тоог саяынхаа 24 сургууль маань аль, аль аймагт хэдэн хүүхдийн сургууль хэрэгтэй юм бэ гээд. Жишээлбэл Завхан, Увс аймагт шинээр сургууль барихгүй саяын нөхцөлийг хангачхаад байна. Гэхдээ насжилттай сургууль тэнд байгаа, тэрийг Боловсролын яамныхаа шугамаараа хийнэ. Миний судалгаа, бид хэдийн ингээд хийгээд байгаа ерөөсөө л боловсролын чанараа ярихын тулд тэр хязгаарыг барья гээд. Энэ дотор тэгээд Өмнөговь аймаг хамгийн их шаардлагатай сургууль, тэгэхдээ бол 960 хүүхдийн суудалтай том сургууль хэрэггүй. Энэ чинь нөгөө сумдаараа хүн ам нь суурьшил нь ихдээд байгаа газар, дараа нь Хөвсгөл байсан, Орхон байсан, ингээд аймгуудад, Сэлэнгэд байсан гээд ингээд гараад ирж байгаа.

Нийслэлийг бид гараад ирэхээр ерөнхий боловсролын сургуулийн байршлууд нь ингэж гарч ирээд, нийслэл дээр судалгааны төв гээд маш сайн тооцооллоо хийж байгаа залуучууд хэд, хэд бараг арваад болчихсон байх. Тэгээд орон сууц буюу нийслэлийн төв рүүгээ 16 сургууль барья. Дэд төв, гэр хороололдоо 23, 45 гэдэг чинь нийт 68 сургуулиа барья. Тэгээд 15 сургуулийг давхарлах шаардлагатай гэсэн тоогоо хийгээд, 84 гэдэг тоон дээрээ бид тохироод, яг ярилцаад байршлаа гаргаад ирсэн нь энэ их давуу тал байгаа. Тэгэхдээ би энэ дээр байршлынх тулгана гэж байхгүй. Газраа бодохгүйгээр эхлээд хүүхдээ их байгаа газар зайлшгүй барих газраа гаргая, тэгээд газар чөлөөлөлтөө нийслэл хийе гэдэг дээрээ бид тохироод ингээд явж байгаа. Тэгэхдээ тэр тохироог Сангийн яамтайгаа хийж байгаа байх.

Шинээр барих цэцэрлэгийн хувьд энэ тооцоонууд гарч ирсэн. 95 цэцэрлэгийгээ орон нутагтаа яах вэ гэхээр орон нутагт 56 цэцэрлэг, цэцэрлэг нь орон нутагт их шаардлагатай. Тэгээд нөгөө зуун хүүхэд нь ортой, 150 ортой гээд, 300 хүртэл ортой цэцэрлэгээр ингэж бодож гаргасан.../минут дуусав/

Улсын Их Хурлын дэд дарга С.Эрдэнэбат 13 цаг 35 минутаас хуралдааныг даргалав.

С.Эрдэнэбат: Галбадрах багш нөгөө цаг 10 минутад багтах ёстой юм байна. Та нөгөө слайдуудаа товч, товч яачхаад бид асуувал.

Ж.Галбадрах: Тэгье, тэгье. Би харин 10 дээр дуусчих байх гээд, одоо надад хэдэн минут байна вэ?

С.Эрдэнэбат: 2 минут хэтэрчхэж, танд 1 минут өгье.

Ж.Галбадрах: 1 минут. Тэгээд энэ 40-өөс ийм сургуулиуд 108, 95 сургуулиа бүр онд нь хуваагаад гаргаад ирсэн байгаа. Дараа нь багшийн хүртээмжийн судалгаа хийсэн. Энэ дээр хүүхдийн тоо өсөхөд багшийн тоо дагаж өсөж чадаагүй нь бид нарт гаре үүсгээд байна гээд. 40 хүртэлх хувьтай сургуулиуд хэд байгаа юм гэдгийн дутагдлууд энэ цэцэрлэг, сургуулиар нь гаргаж ирээд, энэ явахаа байчих гэж байна бүүр. Аймаг, орон нутгаар нь ингээд гаргасныг. Тэгээд энд нэг гараад байгаа нь багшийн ажлаас гараад байгаа хурд байж байна. Тэр нь 16 онд орсон багш 22 онд орсон багш нарыг харьцуулаад харахад ийм зөрөө гараад байгаа юм. Тэгээд багш мэргэжлээрээ ажиллаж байгаа хувиудыг их нарийн тооцож гаргасан 38 хувь дундаж байгаа. Тэгэхээр энэ хувийг нэмэх хэрэгтэй. Багш хэдээр нэмэх шаардлагатай вэ гээд.

Тэгээд хамгийн гол нь саяын цалингийн асуудал яриад байгаа бол 1 сая 484 гэдгийг 2 сая хэрхэн болгож болох вэ, тэрний тулд яах вэ гэдэг асуудал. Тэгээд эхний 5 жил гээд түрүүн яриад байна лээ л дээ. Яг тэр чиглэлээр нь ингээд ийм тооцооллуудыг нэлээн хийсэн. Тэгээд гол нь нөөц багш буюу зах зээл дээр байгаа багш нарыг эргэж ирүүлбэ. Амьдралын чанар буюу ипотекийн зээлээр багш нарын орлогыг нэмэгдүүлбэ. Карьер буюу түрүүн Эрдэнэбат гишүүний хэлсэнчлэн 5 жил ажиллахаар нь гадаадад магистр энэ тэрд сургадаг юм хийж байж энэ хүмүүс үлдэх юм байна лээ. Түүнээс шилдэг хүүхэд бол багш олохгүй юм байна лээ. Тэтгэлэгтэй тэр Казахстанд хийдэг шиг цалинтай оюутан байлгая. Тэгээд багшийг дэмжих хөтөлбөрүүд дээрээ 600-аас дээш оюутанд сар бүр 600 мянган төгрөг өгье ч гэдэг юм уу ийм юм хийхэд 4,2 тэрбум, нөөц багшаа саяын 2 мянган багшийг татахад 10-аас 20 тэрбум ч гэдэг юм уу. Би Сангийн яаманд саналуудаа өгчихсөн байгаа. Ипотекийн зээлд 15-аас 18 тэрбум гээд ингээд бодоход нэг жилд 50 тэрбумыг энэ багш нарыг чанаржуулах, багш нарын бүтцийг бүрдүүлэхэд яаж болох юм байна гэсэн.

Багшийн ажлын байрны судалгааг уг нь энд Сүндарь судлаач маань ирчихсэн байж байгаа. Ерөнхий боловсролын 11 сургуулийн сургуулийн захирал, 656 багшаас аваад, тэгээд Финландад сурч байгаа тэр Ариунхишиг гэж доктортой ингээд харьцуулаад ингээд хийсэн. Үнэхээр л яах аргагүй энэ хүн амын өсөлтөө дагаад цалин нийгмийн баталгаа, энийг нөгөө AI ашиглаад энэ их олон хүнээс авсан саналыг ингээд гаргаад ирсэн байна лээ. Тэгээд энд саяын энэ тоон хомсдол үүсэж байгаа шалтгаан, тоон хомсдолыг багасгах ямар шалтгаан байгаа юм энэ хажууд нь бичээд, дээр нь чанарын хомсдолыг яриад, явахаа байсан байна.../минут дуусав/

С.Эрдэнэбат: Ажлын хэсгийн ахлагч Галбадрах гишүүнд баярлалаа. Саяын танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Мөнхтуяа гишүүн асуулт байна. Мөнхтуяа гишүүнээр тасаллаа асуулт.

Ц.Мөнхтуяа: Галбадрах гишүүн нэлээн сайн судалгаатай, тооцоотой юмнууд хийсэн байна. Энэ дээр миний нөгөө ярьдаг улиг домог болсон нөгөө цалин. Аягүй олон энэ ямар нэгэн энэ орчин нөхцөл, багшийг хомсдолоос гаргахын тулд багш нараа авчрах гол хөшүүрэг чинь ерөөсөө л цалин шүү дээ. Тэгээд цалингаа нэмье гэнгүүт л би буруутан болоод байгаа шүү дээ ер нь, Мөнхтуяа цалингаас өөр юм ярьдаггүй гээд. Тэгээд ер нь бүх сэдэв рүү хальж ороод мэддэг юм шиг, мэдэхгүй байж мэддэг юм шиг царайлж юм ярих би дургүй. Ер нь яг бодит байдал дээрээ өнөөдөр Монголын багш нар цалингаас болж ажлаа хаяж байгаа шүү дээ. Тэрнээс нэг их орчин нөхцөл голоод л юу яачихсан зиндаархчихсан юм бол байхгүй байгаа шүү дээ. Яг амьдралын баталгаа болсон цалин байхгүй. Дээрээс нь нөгөө орон сууц авах гэхээр ипотекийн зээлд хамрагдах цалин нь хүрэхгүй. Ийм л хүнд байдалтай байгаа.

Одоо тэгэхээр энд байгаа боловсролыг төлөөлж байгаа Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнээс хүсэх ганцхан л зүйл байна. Бид олон гоё юм яриад байж болно. Олон ингээд presentation тавиад л, янз бүрийн судалгаа хийгээд яваад байж болно. Тэгээд юу ч өөрчлөгдөхгүй, юу ч өөрчлөгдөхгүй. Ерөөсөө л цалинг нэмж байж бүх асуудал шийднэ гэдгийг л та нар минь нэг ойлгоод өгөөч гэдгийг бүүр үнэн чин сэтгэлээсээ гуймаар байна. 17 оноос хойш л багшийн цалин ярьсан, өнөөдөр ингээд бараг 10 жил ярьж байна шүү дээ. Ичмээр байгаа байхгүй юу.

Тэгээд 28 онд бид юугаа ярьж, эргээд багш нарынхаа өмнө зогсож байх юм бэ? Ялангуяа боловсролоо төлөөлж байгаа бид нар. Тийм учраас бүгдээрээ нэг эв санаагаа нэгтгээд, энд байгаа эрхэм гишүүд бүгдээрээ энэ багшийн цалин дээр аягүй гоё point өгмөөр байна. Ганцхан би багшийн цалин яриад л байхаар одоо бараг улиг домог болж байна. Сүүлдээ би ярих үггүй болж байна, бараг яримааргүй байна. Цалингаа л яримаар байна бид. Энэ олон багшийн хомсдол, энэ олон сурах бичгийн алдаа дутагдал ингээд л бид нарт асуудал байгаа, түмэн асуудал байгаа тоочоод байвал дуусахгүй. Хамгийн чухал юм руугаа point өгөөд, цалингаа яриад, цалин өсвөл энд сайн хүүхдүүд ороод ирнэ. Энэ боловсролын салбарт өрсөлдөөн бий болно.

Өнөөдөр ямар ч өрсөлдөөн байхгүй. Өрсөлдөөнгүй байгаагийн гол шалтгаан ерөөсөө л цалин шүү дээ. Өнөөдөр сая дөрвөн зуухан мянган төгрөг авах гэж өнөөдөр 10 дугаар, 12 дугаар ангийг сайн дүнтэй төгсөж байгаа хүүхдүүд энд юу гэж өрсөлдөх юм бэ тийм биз дээ манайхан, эрүүл ухаанаар бод доо. Тэгээд цалингаа л ярья хэдүүлээ. Цалинг яаж нэмэх вэ. Тэгвэл 10 мянган багш өнөөдөр ажил хаях юм уу, бүүр ажил хаяад энэ боловсролын салбараас нь бүүр яваад бүгдээрээ Солонгост оччихъё тэгвэл. 10 мянган багшийн хомсдолд оръё дахиад. Тэгээд бид энэ гоё сурах бичиг, хөтөлбөр, сургалтын орчин, барилга байшингаа яриад байх юм уу, хүнээ яримаар байна. Багш нарынхаа нийгмийн асуудлыг хамгийн түрүүнд шийдэж байж.../минут дуусав/

С.Эрдэнэбат: Бараг үг хэлчихлээ, Мөнхтуяа гишүүн. Ажлын хэсгийн, тийм, судалгаатай холбоотойгоор тэр 600 хэдэн багш нарын яг нөгөө ажлын ачаалал, тэгээд энэнтэй холбоотой ингээд ажлын нөгөө гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой маргаан гээд л ингээд олон юмнууд байгаа. Тэгэхээр 1 дүгээрт бидний хувьд энэ үндсэн цалингийн асуудлыг одоо энд сууж байгаа манай гишүүд бүгдээрээ л цалингийн асуудал ингээд бараг бүгдээрээ хэллээ. Цалинг ерөнхийдөө ярих ёстой, бүгдээрээ ярьж байгаа, олон хүн байгаа. Энэ чинь 19 гишүүний бүрэлдэхүүнтэй аягүй том ажлын хэсэг байна тийм үү. Тэгэхээр энэ дээр ирэх жилийн төсвийн төлөвлөгөөний анхны хүрээний мэдэгдэл явж байгаа. Багш нартай холбоотойгоор нийгмийн даатгалаас яг багш нарын хэдэн хувь нь төдөөс тэдэн цалин, төдөөс тэдэн хувийг нь тэдэн цалин авч байна гэдэг нэрлэсэн болон гар дээрээ авч байгаа гэдэг ийм судалгаа гарсан байгаа юу? Тийм ээ тийм. Ажлын хэсэг маань 1 дүгээрт бүх шатны сургуулийн багш нарын хомсдолыг бууруулах түлхүүр асуудал нь цалин байгаа нь үнэн.

2 дугаарт нь сургуулийн менежментийн асуудалтай холбоотой асуудал байдаг тийм үү? Энэтэй холбоотой саналууд байж байгаа. Тийм учраас энэ ажлын хэсгийн гаргасан дүгнэлт, санал олон гишүүн оролцсон юм байна. Энэнтэй холбоотойгоор дараагийн ээлжид бид тодорхой энэ төсөв, төлөвлөгөө хэлэлцэж байгаа үед энэ асуудлуудаа маш яаралтай шуурхай яамтайгаа саналаа нэгтгээд, төсөвт Сангийн яамтай болон бусад энэ аймаг, орон нутгаас тийм үү нэмэгдэл цалин хөлс, орлогод хувь нэмрээ оруулах боломж бололцоо юу байна уу гэдэг энэ олон эх үүсвэрүүдийг харах шийдэх ёстой. Өөр санал хэлэх гишүүн байна уу? Асуулт бол хаагдсан. Саранчулуун гишүүн, өөрөө ажлын хэсгийн гишүүн.

О.Саранчулуун: Би одоо бид ингэж байгаа багш, багшийн асуудал гэж ярихлаар багшид тусалдаг туслах багш, багшийн тэр сургуулийн орчинд байгаа бусад нягтлан, сургалтын менежер, нийгмийн ажилтан гэж тухайн нэг хүүхдийг боловсрол олгоход тусалдаг бусад мэргэжилтнүүдийг нь цалингийн тухайд ч тэр,

нийгмийн байдлын тухайд ч гэсэн орхиж болохгүй, цогцоор нь харж өгөх хэрэгтэй байгаа гэсэн үг. Тийм. Нөгөө талд яг энэнтэйгээ адилхан эмч гэхээр бид сувилагчаа хаяад, эрүүл мэндийн нийгмийн ажилтнаа хаяад, нян судлаачаа хаячихдаг байхгүй юу. Багш, эмч 2 гэдэг нь илүү яригдаад, нөгөө дагалдаж тусалж байгаа чухал мэргэжлийн хүмүүсээ бид орхигдуулаад байгаа. Тэгэхээр манай энэ дотор тэр нийгмийн ажилтан буюу сургуулийн нийгмийн ажилтны тухай зүрх сэтгэлийн боловсрол гэж ороод байгаа боловч нийгмийн ажилтны ажил үүргийг нь тодорхойлоод, нийгмийн ажилтан өөрөө нөгөө урьдчилан сэргийлэлт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэлт гэдэгтэйгээ яаж холбогдох вэ гэдэг дээр нэлээн жоохон нухацтай ийм юмнуудыг оруулчихмаар байгаа юм. Энэ нь заавал тийм төсөв яригдаад л, тусдаа тэр байшин сав бариад байхаар шийдэх асуудал биш шүү дээ. Энэ чинь нөгөө нэг өөрөө зүгээр л сургуулийн захирлын, сургуулийн бодлогын сэтгэлийн л асуудал байгаа байхгүй юу. Менежментийн асуудал байгаа.

Тэгэхээр өнөөдөр цахим дээрэлхэлт болон анги танхимд байгаа ил харагдахгүй байгаа дээрэлхэлтүүд хүүхдүүдийн дунд гэхээс гадна багш нарын дунд байгаа. Би зүгээр нэг жишээ хэлэх гээд байгаа. Биеийн тамирын хичээл дээр хүүхдүүдийг өндрөөс нь нам руу зогсоодог доо. Тэр жишээлбэл нэг төрлийн хүнийг гадаад төрхөөр нь дээрэлхэж байгаа, биш ээ ялгаварлан гадуурхаж байгаа хувилбар мөн байхгүй юу. Тэр хүүхдүүд үргэлж сэтгэл санааны хувьд эмзэг байдаг, биеийн тамир хичээлдээ орох дургүй байдаг гэх мэтчилэн ийм хүний эрхийн мэдрэмжгүй багш нарын ийм үйлдлүүд байна. Энийг жишээ болгоод яриад ингээд иймэрхүү маягаар ингээд бид сургууль өөрөө бодлого дотроо өөрчлөлтүүдийг оруулах хэрэгтэй. Би илүү байшин сав ярихаасаа илүү хүмүүсийн одоо хийж байгаа ажлаа шинэ талаас нь хараач гэдгийг яриад байгаа.

Тэгээд бид нарын нөгөө ярьсан 10 асуудлын чинь 5 билүү, 6-д нь зүрх сэтгэлийн боловсрол гэдэг зүйл байгаа. Тэр чинь өөрөө ээж, аавууд болон эцэг, эхчүүдэд хэрэгтэй байгаа. Тэгэхээр энэ тал дээр нэлээн түлхүү юмнуудыг ярьсан ийм агуулгатай байвал би бүх л хуулийн төсөл, бүх л зүйлээр дэмжээд ингээд 5 мөчөө өргөөд ингээд явмаар байгаа байхгүй юу. Ийм санал.

С.Эрдэнэбат: Галбадрах багш, гишүүн.

Ж.Галбадрах: Баярлалаа. Санал хэлсэн хүмүүсийнхээ саналуудыг тусгая. Ер нь хамгийн чухал асуудал маань өөрөө цалингийн асуудал. Цалингийн асуудлыг ерөөсөө энд орхиод байгаа юм бол ерөөсөө байхгүй. Тэгээд багшийн ажлын байрны нөхцөлийн талаар та нарт тараасан presentation дотор бичсэн байж байгаа, тэнд угаасаа тэр судалгааг сайн хараарай. Олон улстай харьцуулаад яг Монголынхоо байдал дээр маш сайн судалгаа хийчихсэн байж байгаа. Жишээлбэл 1-ээс 2 жилийн дотор 41 хувь нь ажлаа өөрчилж гэсэн сэтгэл зүйтэй байна гэдэг ч юм уу ноцтой, ноцтой дүгнэлтүүд гараад ирсэн байгаа. Тэгэхээр бүгдээрээ энэ талаа бодит байдлаа нэг эгцэлж харчхаад, тэгээд энэ эгцэлж харсан бодит байдал дээрээ бүгдээрээ асуудлаа шийдээд явна.

Багшийн цалингийн хувьд шууд ингээд цалинг тэд болгоно гэхээр эрүүл мэнд эмч нар, төрийн албаныхан гэдэг ийм барьцаж, нийгмээ цалинг нэмэх асуудлыг бүхэлдээ улсын төсөв харж байгаад шийдэж байна. Тэгвэл бид өнөөдөр багшийн цалинг яаж нэмж болох вэ гэдэг асуудлуудыг харин их оновчтой, ухаалаг ийм байдлаар. Жишээлбэл багшийн хишиг ч гэдэг юм уу би түрүүн хэлж байна л даа. 1 сая 480 мянган цалинтай анхны гарааны цалин нь ийм байгаа хүмүүсийг

яавал 2 сая болгочихвол тэр багш нар тогтох юм байна гэдэг судалгаа гарчхаад байгаа юм. Тэгвэл 2 сая болгохын тулд тэнд 500 мянган төгрөгийг бид хаанаас эх үүсвэрээс шийдээд, багш нар, залуу багш нарт өгөөд явах вэ 5 жилийн дотор. Дээрээс нь багш нарын үндсэн цалин гэж нэрлэж бусад хүмүүст яадаггүй юмаа гэхэд бид багш нарын цалин дээр тэр анги даасан багшийн цалин гэдэг чинь маш бага болчихоод байна. Тэрийг хэдээр нэмж болох вэ гэдэг ийм судалгаанууд бид нэлээн хийчихсэн байгаа юм. Наад өгсөн материал дотор байж байгаа. Анги даасан багшийн цалинг нэмье, мөн дэвтэр засалт гэдэг шиг сургууль дээр ажиллаж байгаа багшийн тэр цалин болгон, тэгээд тэр гүйцэтгэлийн үнэлгээний талаар түрүүн Эрдэнэбат гишүүний яг хэлсэнчлэн тийм сөрөг үр дүн гараад байгааг нь биччихсэн. Тэгвэл тэр үнэлгээ дээр нь үндэслээд, тэр үнэлгээ дээр үндэслэсэн цалингуудыг заавал цалингийн сүлжээнд орж, нийтэд зарладаггүй юмаа гэхэд багш нарыг дэмжих байдлаар юм оруулдаг ийм саналуудыг оруулаад, энийгээ бид зоригтой хуульчлаад явах ёстой гэсэн ийм санал дүгнэлтүүд байгаа.

Яалт ч үгүй л бид ингээд гоё, гоё presentation тавиад байна гэхээсээ илүү бид энэ судалгаа дээр явж, судалгаа дээр үндэслэсэн юм маань урт явна. 665 багшаас санал сонсоход үнэхээр амьдралтай бодитой чухал саналуудыг хэлсэн. Ялангуяа захирлуудтай нь бүр чанарын сургалт, 3 цаг бүр ярилцаж энэ судалгааны багийнхан авсан байна лээ. Тэгээд тэрнийх нь ингээд маш том presentation-үүд, маш том үр дүн, өгөгдлүүд гарсан. Энэ дээр тэгээд л яалт ч үгүй цалин нэмэх хэрэгтэй. Нийгмийн асуудлыг шийдэх ёстой, ипотекийг зээлэх ёстой. Би тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамтай ипотекийн зээлийн талаар бид яриа өрнүүлээд, энэ дээр тэр ипотекийн анхны тэр зээлийн баталгаа гэдэг юмыг нь 30 сая төгрөгийг бид багшид өгдөг больё ч гэдэг юм уу. Тэгэхдээ энэ бол шийдчихсэн асуудал биш. Тийм учраас шийдээгүй байгаа учраас тийм олон нийтэд бид нээлттэйгээр ярих хараахан боломжгүй байна. Тэгэхдээ энийг бид шийдүүлэхийн төлөө явах ёстой ийм энэ тал дээр хуулийн санаачилгууд, янз бүрийн зүйлийг журамд өөрчлөлт оруулах энэ ажлуудыг ажлын хэсгийнхээ үр дүнгээр хийгээд явна гэж ингэж бодож байгаа.

Манай ажлын хэсэгт орон нутгийн аймаг, орон нутагт Засаг дарга хийж байсан 4 хүн байдаг дүүрэгт. Тэр хүмүүс энэ багийн сургуулийн асуудал, энэ жижиг бага сургуулийн асуудлуудыг маш тодорхой гаргаж ирж байгаа. Тэгээд бид 1-ээс 2 дугаар ангид тэр багийн сургууль, тэр явуулын сургууль энэ тэрийг Лхагвасүрэн судлаач энэ тэртэй бид хамтраад энэ асуудлыг ажлын хэсэг дээрээ гаргаад, мэдээж Байнгын хороогоороо оруулна. Тэгээд Байнгын хороон дээрээ оруулж ирж байгаад санал, дүгнэлт сонсож байгаад цааш нь яг ном ёсоор нь зарчмынх нь дагуу явна гэж бодож байгаа юм. Баярлалаа.

С.Эрдэнэбат: Баярлалаа. Тэгээд энэ өөрөө маш их чухал нөгөө гол түлхүүр асуудал энэ тусгайлан ажлын хэсэг гаргачихсан цалин хөлс, багшийн хомсдолын гол хүчин зүйл бол сая Галбадрах ахлагчийн хэлдэг орон сууц бол бас яах аргагүй мөн. Боловсролын салбарт дор хаяж 10 жил ажилласан хүн бол 2 өрөө байртай байх энэ баталгааг нь л бид өнөөдөр шийдэж өгч байж, өнөөдөр тийшээ багшаар сурах уу, эргэж ирж очиж багшлах уу гэдэг энэ юм шийдэгдэнэ. Тийм учраас энэ орон сууцын хөтөлбөрт нэн түрүүнд хэдэн багшийг, хаана, яг яаж өгөх юм бэ гэдэг юмыг Боловсролын яамтай, Барилга орон сууц, барилгын яамтай яриад, мөн банкнуудтай яриад ингээд шийдэхгүй бол банкнаасаа зээл авбал багш чинь 1 сая 400 мянган төгрөг ямар юмныхаа моргейжийн зээл авах вэ дээ. Тийм учраас тэр тэтгэврийг нь барьцаалдаг юм уу, нийгмийн даатгалынх нь санд нь мөнгө байвал

тэрийг нь барьцаалж гэдэг юм уу арай хөнгөн журмаар хурдан шийдэх энэ асуудлаа тавимаар байгаа юм.

Тийм учраас энэ тал дээр дараагийн ээлжид энэ Барилгын яам, энэ Орон сууц, ипотекийн корпорац эд нарыг байлгаж байгаад яг тодорхой ажил хэрэгч асуудлуудаа ажлын хэсгийн ахлагч тусгайлан уулзах хэрэгтэй болов уу гэж би бодож байна. Тэгэхгүй бол энэ ногоон нуурт баригдсан байж байгаа орон сууцыг төрийн албан хаагч нарт өгнө гээд л байдаг. Тэгээд баахан хүмүүс ордог. Тэр дунд нь багш нар нь хоцорчих вий. Дээрээс нь дахиад хэд хэдэн хоосон орон сууц байгаа гээд байгаа. Борлогдохгүй байгаад байгаа гээд байгаа. Тэрийг тэгвэл багш нарт урт хугацааны тэр ипотекийн зээлийн хувьд дүүрэг дүүргээр нь, аймаг аймгаар нь гэдэг байдлаар бүүр нарийн тоо яриад, энийг шийдэхэд тэр Монголбанк нь байна уу, арилжааны банкнуудтай ч гэсэн бид нөгөө энэ талаар би хамтарч ажиллаж болох болов уу гэж бодож байна.

Цалингийн хувьд хэдүүлээ ирэх жил боловсролын жил болгочихсон. Тийм учраас багш нарынхаа цалин хөлс, орлогыг тусгайлан нэг онцлоод аваад үзчихье энэ жилдээ гэдэг байдлаар нэг тавьж үзье гэж би бодож байна. Тэгэхээр энэ тал дээр Сангийн яамтай энэ ажлын хэсгийн гишүүд, хэдүүлээ энэ Байнгын хороо маань тусгайлан нэг тодорхой төлөөлөл багш нар, гишүүд ороод нэг уулзвал яадаг юм бэ. Тэгэхгүй бол одоо энэ төсөв боочихсон, эргээд задлахад төвөгтэй байдаг шүү дээ.

Дээрээс нь аймгийн төсөв дотор нөгөө нэмэгдэл урамшуулал 100 хувь хүртэл авч болно гээд шийдсэн чинь энийг зөвхөн нөгөө нэг аймгийн ЗДТГ-т ажилладаг зарим хүмүүс л авдаг. Нөгөө боловсрол, эрүүл мэндэд яах вэ нөгөө 40 хувийн нэмэгдэл бол сумынхан бас нэг том алхам гэж хэлж байна лээ. Аймагт болон Улаанбаатар хотод байгаа багш байж байгаа ямар нэгэн нэмэгдэл авдаггүй. Тэгсэн мөртөө саяын ачааллын чинь дийлэнх нь 49-өөс 50 хэдэн хүүхдүүдтэй байгаа чинь Улаанбаатарт л байгаа шүү дээ тийм үү, дийлэнх нь. Тэгээд энэ хүмүүст ачааллын нэмэгдэл гэдэг зүйлийг энэ өгвөл яасан юм бэ гэдэг ийм саналууд их гарч байсан багш нарын хувьд. Дээрээс нь багш нараа түрүүн би хэлсэн. Боловсролын зээлийн сангаасаа 5 жил ажиллачихсан багшийг гадагшаа нэг явуулаад ирдэг, эргэж ирээд ч 5 жил ажиллана шүү гэдэг нэг гэрээгээр ингээд ийм байдлаар залуу багш нарыг тогтоон барих хөшүүрэг болгох болов уу гэж би бодож байна.

Тэгээд багшийг бэлдэж байгаа ялангуяа МУБИС гэдэг юм уу ийм сургуулиудыг багш нарыг нь хамгийн түрүүнд тэр хүмүүсийг сургамаар байгаа юм. Багшийг бэлдэж байгаа багшийг. Ийм мэтчилэн ингээд цогц арга хэмжээнүүдээ ингээд аваад, өнөөдөр сургуулиа төгсөх гэж байгаа хүүхдүүд багш бол би ирээдүйд ямар, ямар баталгаагаар хангагдах юм бэ, энэ тал дээр манай Үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд хамтраад олон талын санал шаардлагуудыг өгч байж зарим зүйлүүдийг нь шийдүүлсэн. Гэхдээ л багш гэдэг зүйлийг онцолж авч үзье гэхээр бусад салбарууд барьцана гэдэг нэг ийм ойлголт яваад байна. Тэгэхээр энэ асуудлыг бид эцэг, эхчүүддээ хүртэл ойлгуулах хэрэгтэй юм байна лээ. Өөрөөр хэлбэл чиний хүүхдэд хичээл зааж байгаа эцэг, эхчүүддээ энэ хүртэл ойлголт өгөхгүй бол тэгээд эцэг, эхчүүдийн зүгээс ч гэдэг юм уу, олон нийтийн зүгээс багшийг нэг камер бичлэг хийгээд л нийтээр нь цацчихдаг. Энэ өөрөө эргээд бараг ажлын байрны хүчирхийлэлд хүртэл орох асуудал байгаа байхгүй юу.

Тийм учраас бидний хувьд энэ багшийгаа нэн түрүүнд авч үзэх гээд ирэх жил боловсролын жил болгон зарлуулахад бидний хувьд онцолж зарлуулсан. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын тэргүүнээр. Энийгээ ашиглаж аваад боловсролын жилийн төсөв гэдгээр нь онцолж авч үзье. Ирэх жилийн төсөв гэж байгаа учраас. Ийм байгаа учраас ажлын хэсгийнхээ гишүүдэд их баярлалаа. Тэгээд энэ явцынхаа тайлан бол нарийн судалгаанууд хийсэн байна. Энийгээ олон нийтэд хувааж аваад бид танилцуулах хэрэгтэй байгаа байх сэдэв сэдвээр нь. Тэгээд энэ чиглэлээр Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан учраас Их Хурлын даргад ажлын хэсгийн ахлагч болон гишүүд танилцуулаад, тэгээд Байнгын хороон дээрээ тодорхой, тодорхой саналуудаа оруулаад яаралтай шийдэх байх. Одоо ингээд хаврын чуулган 7 сар гээд үндсэндээ бараг хаахаас өмнө бид нарт хэд, хэд хуралдах нэг ийм юу байгаа, энүүгээрээ асуудлуудаа оруулаад, намар төсөв гэхэд бидний хувьд нэг багцлаад төсвөө оруулж ирээд, тэгээд 19 гишүүн байна гэдэг бол энэ хөдөө орон нутгийн гишүүд байна, олон гишүүд байгаа учраас нөгөө лоббигоороо яриад, лобби бүлгээр ярьж аваад, тэгээд боловсролын жилдээ бидний барих төсөв энэ байна, бодлого нь энэ байна, хууль нь энэ байна гэдэг байдлаар нэг маш чухал гэсэн 5 асуудлыг барьж аваад л үүнийхээ төлөө явъя. Олон юмны төлөө явахаар ерөөсөө саармагжаад болохгүй байх. Бусад асуудлыг нь байна.

Тэгээд манай Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороонд дандаа багш байсан хүмүүс байгаа. Нийгмийн бүлгийн төлөөлөл гээд, Мөнхтуяа гишүүн бид хоёрын хувьд энэ Үйлдвэрчний эвлэл, ажилчдын төлөөлөл гэж байгаа. Галбадрах багш бол өөрөө багш байсан хүний хувьд байна, Саранчулуун багш байна, Бум-Очир багш байж байна, манай Сарнай гишүүн энэ тэр гээд идэвхтэй дэмждэг, ядаж энэ Байнгын хороо маань санал нэгтэй байгаад нь баярладаг. Тэгээд энэ боломжоо ашиглаад хэдүүлээ энэ ажлын хэсгийнхээ явцыг танилцлаа. Тэгээд Их Хурлын даргатай ойрын хугацаанд та бол уулзах хэрэгтэй байх. Тэгээд Байнгын, дараагийн байнгын хороогоор тусгайлсан энэ саналуудыг мөн Эдийн засаг болон Төсвийн байнгын хороод дээр манай гишүүд маань хуваагдаад орох хэрэгтэй шүү. Би Эдийн засгийн хороонд очиж, өнөөдрийн энэ асуудлуудыг төлөвлөгөөний юмыг танилцуулна. Тэр үед хэдийгээр тэр хороод Байнгын хороодын гишүүд биш ч гэсэн манай Боловсролын байнгын хорооны гишүүд ороод өөрсдөө асуудлаа хамгаалаад яриад, саналаа хэлээд. Галбадрах багш бараг наад асуудлаа илүү арай товчилж байгаад, яг цалин, орон сууц, юу гэдэг ийм 3 асуудлаа бариад ч юм уу Төсөв, Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалт ийм хороодоор оруулаад ингээд та саналаа танилцуулаад явсан нь дээр байх.

Тэгэхгүй бол зөвхөн Эдийн засаг, Төсөв гээд өөр салбарын олон асуудал байгаа. Энийг ойлгох ч хүн байгаа, ойлгохгүй ч хүн байгаа учраас ингэж хийе. Өнөөдрийн хуралдаан ажлын хэсгийн ахлагч Галбадрах багшид нэлээн цаг хугацаа зарж, явцын тайлангаа танилцуулсанд баярлалаа. Үүнийгээ хуралдаанд оролцсон гишүүд маань дэмжиж үг хэллээ. Дараагийн хурлаар Их Хурлын даргатай та уулзах юм байна ажлын хэсгийн журмаар. Тэгээд авах арга хэмжээнийхээ төлөвлөгөөнүүдийг хэдүүлээ ажлын хэсэг дотроо ярих байх. Ажлын хэсэгт ороогүй ч гэсэн Байнгын хорооны гишүүд ингээд ороод саналаа хэлээд явъя.

Тэгээд дараагийн Байнгын хороо, давхар Нийгмийн бодлого дээр оруулах хэрэгтэй юм байна лээ шүү. Нийгмийн бодлогын юман дээр нөгөө тэр орон сууцын асуудал, нөгөө цалингийн асуудал чинь. Тэгээд энүүгээрээ хувааж аваад ингээд

явъя. Тэгээд өнөөдрийн хуралдаанд мэдээлэл хийсэн Галбадрах багшид баярлалаа. Үг хэлсэн гишүүдэд, санал хэлсэн гишүүдэд баярлалаа.

14.01 цаг

Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА